

НИЙГМИЙН СОНИН

☉ Монголын хөлбөмбөгийн шигшээ багийг тоглолт наймаалцаагүй гэж дүгнэлээ

➔ 3

ЗГМ: СЭДЭВ

☉ Улаан сайдын уршиг хийгээд ноолуур тойрсон дампуу

➔ 4

НИЙГЭМ

☉ Н.Мандуул: Хүүхдүүдийг зусланд эцэг, эхтэй нь хамт амраах санал дэвшүүлсэн

➔ 6

ZGM DAILY

☉ FULL ENGLISH PAGE INSIDE

➔ 20-21

ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ

TDB ONLINE
Банкны бүх төрлийн үйлчилгээг нэг дороос

2020.05.29, БААСАН~№093 (1372)

~ ИРГЭН БАЯН БОЛ УЛС БАЯН ~

₮1000, 24 НҮҮР

АЛТ	ЗЭС	ТӨМРИЙН ХҮДЭР	НЕФТЬ	ЧИНГИС БОНД	ХУРАЛДАЙ БОНД	ГЭРЭГЭ БОНД	САМУРАЙ БОНД	АМ.ДОЛЛАР	ЮАНЬ	РУБЛЬ	ВОН
1738.70 0.69%	5,259.50 1.91%	610.00 6.15%	34.66 0.23%	99.24	102.00	93.54	102.14	2,806.96	392.20	39.47	2.26



“ОЮУТОЛГОЙ”-Н ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ЗОГСВОЛ МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСАГ ЗОГСОНО

2019 онд гадаадын шууд хөрөнгө оруулалт дөнгөж нэг тэрбум ам.доллар ялимгүй давсан. Эдийн засаг сэргэж байсан 2011, 2012 онтой харьцуулахад энэ нь тав дахин буурсан дүн юм. Нийт хөрөнгө оруулалтын 80 хувийг “Оюутолгой” дангаар бүрдүүлжээ.

☉ Төрийн байгууллагууд эрх баригчдыг “долоож”, бодит байдлыг нууж эхлэв

➔ 7

Хууль, шүүхийн байгууллагынхан сонгуульд зориулж эрх баригчдад үйлчилж байна гэх хардлагыг төрийн байгууллагууд баяжуулж байна.

☉ Уран зурагтай нөхөрлөж, алжаалаа тайлаарай

➔ 12

Ялангуяа абстракт зураг зурахад хүүхэд болоод том хүний дотоод бухимдал гадагшилж, өөрийгөө таньдаг аж.

☉ М.Баярбат: Өөрийнхөө өнцгөөр ертөнцийг харвал илүү өнгөлөг

➔ 17



☉ The Voice шоу бол үндэсний урлагаа сурталчлах маш том боломж

➔ 18



Өнөөдөр	Маргааш
6°C ☁	12°C ☁
-2°C 🌙	0°C 🌙



УЛС ТӨР

МАН өөрсдийн ЖДҮ, 60 тэрбум, концесс, аллага, хүчин, хулгайгаа нуух гэж сөрөг хүчнээ гүтгэж байна

Нэр бүхий 10 гаруй нэр дэвшигчийг ял авсан мэтээр гүтгэжээ

Б.Сэлэнгэ, ЗГМ сонин

Ардчилсан намын Ерөнхий нарийн бичгийн дарга Ц.Баатархүү мэдээлэл хийж, УИХ-ын ээлжит сонгууль болох гэж байгаатай холбогдуулан сонгогчдыг үл хүндэтгэсэн, зарим нэр дэвшигчийг гүтгэсэн увайгүй мэдээллийг улс төрийн намууд явуулахгүй байхыг сануулав. Тэрбээр “Эрх барьж буй МАН өөрсдийн ЖДҮ, 60 тэрбум, концесс, аллага, хүчин, хулгайгаа нуух гэж сөрөг хүчний намууд руу гүтгэсэн, харлуулах үйл ажиллагаа явуулж буйд Ардчилсан нам харамсаж байна. Иймэрхүү гүтгэлгийн шинжтэй суртлыг хэн, хаанаас явуулж байгааг АН-ын хуульчид олж тогтоосон. Сонгууль бол нэг улстөрч нөгөө улстөрчөө муулдаг асуудал биш, харин бодлогын өрсөлдөөн. Ардчилсан нам сонгуулиар шударга өрсөлдөхийг уриалсан. Харамсалтай нь, АН-ын 76 нэр

дэвшигчийг Сонгуулийн ерөнхий хороо албан ёсоор бүгдийг нь бүртгэсэн байхад зарим гишүүнийг бүртгээгүй хэмээн төөрөгдүүлсэн мэдээлэл тарааж байгаад харамсаж байна. Цагдаагийн ерөнхий газар нэр дэвшигчдийн талаар өмнө нь ял шийтгэл авсан эсэх талаар лавлагаа авдаг бөгөөд манай 76 нэр дэвшигч авлига, албан тушаалын хэрэгт холбогдож байгаагүй, татварын өргүй гэх мэт холбогдох мэдээллүүд нь хуульд нийцсэн гэдгийг баталгаажуулж, үүнийг нь Сонгуулийн ерөнхий хороо бүртгэсэн. Энэ бүхэн өөрсдийнхөө алдааг нууж, бусад өрсөлдөгчөө харлуулах гэсэн оролдлого гэж харж байна. Сонгогчид хэнийг сонгох вэ гэдгээ хэн нэгнээр заалгахгүй сонголт хийнэ. Иргэд сонгогчийн сонгох эрхийг хүндэтгэж, хэтэрхий их мөнгө төлж бие биенээ харлуулж байгаад өөрсдийгөө хамгаалсан арга ядсан арга гэдгийг иргэд олон түмэн үзэж байгаа юм. Ардчилсан нам Монголын ард түмний мэргэн сонголтод итгэж байна. Сонгогч



Гэрэл зургийг С.Батсайхан

түмнээ хүндэтгэж байна” гэв.

Ийнхүү мэдээлэл өгсний дараа дараах тодруулгыг Ардчилсан намын Ерөнхий нарийн бичгийн дарга Ц.Баатархүүгээс тодрууллаа.

-Ардчилсан намын хэн, хэн гэдэг нэр дэвшигчийг яаж гүтгэсэн бэ. Хууль эрх зүйн ямар хариуцлага хүлээлгэх вэ?

-Нэр бүхий 10 гаруй нэр дэвшигчийг ял авсан мэтээр гүтгэсэн. Гэтэл хуулийн байгууллага тийм зүйл байхгүйг нь баталгаажуулсан. Хуулийн байгууллагуудад тодорхой асуудлаар гомдол мэдээлэл гаргасныг богино хугацаанд шалгах үүрэгтэй. Хэн нэгэн нэр дэвшигч бусдыг гүтгэсэн нь тогтоогдвол хуулийн хариуцлага хүлээлгэнэ гэж хуульд заасан.

-Танай нам хандивын дансаа нээсэн үү?

-Ардчилсан нам хандивын данс нээсэн. Бүх нэр дэвшигчийн хандивын данс нээлттэй, ил тод түмэн олонд нээлттэй байхаар ажиллаж байна. ■



МАН-ын 2016 оны сонгуулийн мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийг нэхэн сануулж байна.

“ 1.4.5 Хувийн хэвшлээ бүх талаар дэмжих, ЖДҮ, өрхийн болон бичил зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх, хөнгөн үйлдвэрийн салбарыг сэргээн хөгжүүлэх, “21:100”, “Монгол мал”, “Атрын аян” зэрэг томоохон хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх замаар хөдөлмөр эрхлэлтийг тууштай дэмжинэ. ”

Н.Номтойбаярыг албадан саатууллаа

Хуулийн байгууллага МАН-ын харуул хамгаалалтын алба шиг ажиллаж байна

Б.Энх, ЗГМ сонин

УИХ-ын сонгуульд Хан-Уул дүүрэгт нэр дэвшигч, гишүүн Н.Номтойбаярыг өчигдөр таслан сэргийлэх арга хэмжээ авлаа. Түүнд холбогдох эрүүгийн хэргийн урьдчилсан хэлэлцүүлэг Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд болсон юм. “Прокуророос гаргаж өгсөн баримт, хүсэлтийн дагуу Н.Номтойбаярыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.2-т заасан “...мөрдөгчийг дарамталсан, үндэслэл бүхий баримт, мэдээлэл байгаа” гэх үндэслэлээр дараагийн шүүх хуралдаан болтол түүнд урьд авсан Монгол Улсын хилээр гарахыг хязгаарлах хязгаарлалт тогтоох



Гэрэл зургийг С.Батсайхан

таслан сэргийлэх арга хэмжээг өөрчилж, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авахаар

шийдвэрлэсэн” гэжээ.

Харин энэ талаар нэр дэвшигч Н.Номтойбаярын өмгөөлөгч “УИХ-

ын сонгуулийн 35.1-д тухайн нэр дэвшигчийг баривчлах, хорих бол СЕХ-ноос зөвшөөрөл авах зохицуулалттай. Н.Номтойбаяр Хан-Уул дүүрэгт бие дааж нэр дэвшихээр СЕХ-ноос тогтоолоо авчихсан. Энэ байдлыг шүүх мэдсээр барьж цагдан хорьж байгаа нь цэвэр улс төрийн зорилготой” гэв.

Түүнийг дараагийн шүүх хурал хүртэл таслан сэргийлэх шүүхийн шийдвэр гарсан тул нэр дэвших эрх нь байгаа эсэх дээр СЕХ-ноос тайлбар авсан юм. СЕХ-ны Хууль, Эрх зүйн хэлтсийн дарга Д.Бат-Эрдэнэ “Шүүхийн эцсийн шийдвэр гарч гэм буруутайд тооцоогүй учраас нэр дэвшигчээс хасахгүй. Хоригдсон хүн бүрийг нэр дэвшигчээс хасдаггүй. Гэм, буруутай эсэх шүүхийн шийдвэр

гараагүй, урьдчилан хорьж байгаа бол нэр дэвших эрх нь хэвээр хадгалагдана” гэлээ.

Шүүхээс түүнийг таслан сэргийлэх арга хэмжээ авах шийдвэр гаргасны дараа нэр дэвшигч Н.Номтойбаяр өөрийн твиттер хуудастаа “Ноёнтэй тэрсэлдсэн хүн хормойгүй гэдэг ардын үг, улс төр орсон цагт хууль хамаагүй гэж миний хэлсэн үг үнэн боллоо. Чингэлтэй дүүргийн шүүгч намайг хорих шийдвэр гаргалаа. 461 дүгээр хорих ангиас УИХ-ын сонгуульд Хан-Уул дүүргээс нэр дэвшээд гараад ирэхийг харъя гэж байгаа бололтой. Өнөөдрийн хуулийн байгууллага МАН-ын харуул хамгаалалтын алба шиг ажиллаж байгаа нь миний нэр дэвшиж байгаагийн нэг үндэслэл. Иргэд хүчтэй” хэмээн бичжээ. ■



Монголын хөлбөмбөгийн шигшээ багийг тоглолт наймаалцаагүй гэж дүгнэлээ

Хөлбөмбөгийн шигшээ багийнхан Г.Дашнямыг уучлалт гуйхыг шаарджээ

Б.Мөнхзул, ЗГМ сонин

Хөлбөмбөгийн 2022 оны ДАШТ-ий урьдчилсан шатанд таарсан Монгол, Кыргызстаны шигшээ багийн тоглолт манай улсын талбайд болж, 2:1-ээр зочин багийн ялалтаар өндөрлөсөн. Гэвч энэхүү тоглолтыг наймаалцсан байх магадлалтай гэдгийг МХБХ-ны дэд ерөнхийлөгчөөр ажиллаж байсан Г.Дашням хэвлэлд өгсөн ярилцлагадаа болон өөрийн цахим хуудсаараа дамжуулан дурдсан юм. Тэгвэл FIFA уг тоглолтын үр дүнд орсон эсэхийг таван сарын турш шалгасны эцэст “Тоглолт наймаалцаагүй” гэж дүгнэжээ. Тиймээс Монголын хөлбөмбөгийн холбооны тамирчдын зөвлөлөөс дэд ерөнхийлөгч асан Г.Дашнямыг шигшээ

“БИДЭНД ИТГЭЖ, ХҮЛЭЭЦТЭЙ ХАНДАЖ БАЙСАН МОНГОЛЫН СПОРТ СОНИРХОГЧИД, МЯНГА МЯН-ГАН ХӨГЖӨӨН ДЭМЖИГЧДЭДЭЭ БАЯРЛАЛАА. МОНГОЛЫН ШИГШЭЭ БАГИЙН ТУХАЙ ТАШАА МЭДЭЭЛЭЛ ТАРААЖ, ГҮТГЭСЭН Г.ДАШНЯМ БИДНЭЭС УУЧЛАЛТ ГУЙНА ГЭЖ НАЙДЪЯ. ГУЙХЫГ ШААРДАЖ БАЙНА” ГЭЖЭЭ.

багийн тамирчдаас уучлалт гуйхыг шаарджээ. Шигшээ багийн тамирчдын төлөөлөл энэ талаар сошиал орчинд

“Бидэнд итгэж, хүлээцтэй хандаж байсан Монголын спорт сонирхогчид, мянга мянган хөгжөөн дэмжигчдэдээ баярлалаа. Монголын шигшээ багийн тухай ташаа мэдээлэл тарааж, гүтгэсэн Г.Дашням биднээс уучлалт гуйна гэж найдъя. Гуйхыг шаардаж байна” гэжээ. Тэгвэл шигшээ багийн ахлагч Н.Цэдэнбал “Цаашид Монголын тамирчдыг тэр тусмаа хөлбөмбөгийн тамирчдыг гутаан доромжилсон үйлдэл гаргахгүй байгаасай. Энэ бол хөлбөмбөгчдийн хувьд хамгийн гунигтай явдал боллоо. МХБХ-ны дэд ерөнхийлөгч, “Улаанбаатар сити” клубийн эзэн Г.Дашням таныг Үндэсний шигшээ баг, түүний тамирчдын нэр хүндийг гутаан доромжилж, дэлхий нийтэд эсрэг сурталчилгаа хийсэн шигээ, уучлалт хүсч, хөлбөмбөгийн ертөнцөд эргэн нэгдэхийг хүсье” хэмээн бичсэн. ■

“Алтан өргөө” цахим кино наадмын шилдгүүд тодорно

Монголын кино институтсээс зохион байгуулдаг “Алтан өргөө” олон улсын кино наадам коронавирусийн улмаас цахимаар болно. Тус наадмын эцсийн шатанд 14 бүтээл тунаж үлдсэн бөгөөд АНУ, ОХУ, Франц, Швейцарь, Ирландын уран бү-

тээлчдийн киноноос гадна Монголын 10 орчим бүтээл тунаж үлджээ. Уран бүтээлчид баримтат, хүүрнэлт, хүүхэлдэйн кино болон эксперименталь гэсэн үндсэн төрлөөс гадна Milky way хүүхдийн сэдэвт төрлийг нэмж өрсөлдүүлэх гэнэ. Долоо дахь жилдээ болж буй

тус наадам нь Монголын үзэгч нарт арт киног таниулах, гадаадын уран бүтээлчдээс урам зориг авч, хөгжих боломжийг олгох зорилготой аж. Энэ жилийн наадмын гол онцлог нь хүүхдийн хүчирхийллийн эсрэг дуу хоолой болсон бүтээлүүд олноор бүртгүүлжээ. ■

Далай лам өнөөдөр абшиг хүртээнэ

Дээрхийн гэгээнтэн XIV Далай лам өнөөдөр, маргааш 11:30-13:00 цагийн хооронд цахим сүлжээгээр дамжуулан сүсэгтэн олонд Жанрайсиг бурханы абшиг хүртээхээр болжээ. Номын айлдварыг сонирхсон хүмүүс Далай ламын албан ёсны <https://mn.dalailama.com/live> болон Facebook-ийн <https://www.facebook.com/Dalailama> цахим хуудсаар монгол, төвд, англи, хятад, хинди, франц, орос, испани, вьетнам, япон,



солонгос, герман, португал, итали хэл дээр хүлээн авч үзэх боломжтой.

АНУ-д коронавирусуур монгол хүн нас барсан уу

Хоёр хоногийн өмнө зарим сайтаар АНУ-д монгол хүн коронавирусуур нас барлаа гэх мэдээлэл цацагдсан. Тухайн иргэн нь такси компанид жолоочоор ажилладаг бөгөөд сахарын өвчтэй, элэгний хатууралтай байжээ. Нас барахаасаа өмнө олон өдөр халуурсан гэх мэдээлэл бий. Түүнийг монгол дахь ар гэрийнхэн нь коронавирусуур нас барсныг Элчин сайдын яамныхан нууж байна хэмээн хардаж байгаа.

Талийгаач 40 гаруй насны залуу. Дөрөвдүгээр сарын дундуур халуурсаар байгаад өөд болсон аж. Тэрбээр байнга сахарын шинжилгээ өгдөг байсан бөгөөд хүнд өвчтэй биш байжээ. Түүнийг нас барахад сахарын өвчин нь мөн нөлөөлсөн гэж шүүх эмнэлгийн дүгнэлт гарсан юм байна.

Дашрамд дурдахад, АНУ-д нийгмийн даатгалын дугаартай, бичиг баримттай хүүхдэд 500, том хүнд 1200 ам.доллар олгож байгаа юм. ■

Хөдөлмөрийн баатар С.Чоягийн унаж байсан ГАЗ-51 машиныг хөшөөнд мөнхөлжээ

Казах үндэстний дундаас төрсөн цөөхөн Хөдөлмөрийн баатрын нэг С.Чоягийн унаж явсан ГАЗ-51 машиныг Баян-Өлгий аймгийн Авто тээврийн төвийн өмнө хөшөө болгон мөнхөлжээ. “Монголын анхны саятан жолооч” хэмээн алдаршсан С.Чоя нь 1954-1994 онд Баян-Өлгий аймгийн Авто тээврийн бааз, Тээврийн удирдах газарт шуудан тээврийн жолоочоор 40 жил ажиллажээ. Тэрбээр ГАЗ-51 машинаараа Алтайн уулархаг нутгийн



бартаат замд их засваргүйгээр 534 мянган км явсан гэдгээрээ алдаршсан нэгэн. Мөн бааздаа саятны хөдөлгөөн өрнүүлэн, бригад тэргүүлэн ажиллахдаа дөрвөн удаа саятан, долоон удаа улс, аймгийн аварга болжээ. Түүнд 1980 онд БНМАУ-ын Хөдөлмөрийн баатар цол хүртээсэн байна. ■

Төөрсөн хосыг Шинэ Зеландын цөлөөс 19 хоногийн дараа олжээ

Шинэ Зеландын алдартай хөтөлөгч Жессика О'Коннор, тогооч Дион Рейнольдс нар тавдугаар сарын эхээр Шинэ Зеландын Кахуранж үндэсний цэцэрлэгт хүрээлэн рүү аялахаар гарчээ. Тэд 6-7 хоногийн хугацаанд дээрх цэцэрлэгт хүрээлэнгээр аялахаар төлөвлөсөн ч Кахуранжид өтгөн манан татсанаар төөрчээ. Хосууд төөрч явахдаа Коннор нуруугаа, Рейнольдс шагайгаа гэмтээсэн байна. Шинэ Зеландын цөлд 10 гаруй хоног уснаас

өөр амь зогоох зүйлгүй байсан хосыг аврагчид асаасан түүдэг галын утаагаар нь эсэн мөнд олжээ. Цагдаагийн газрын эрэн хайх, аврах ажиллагааны зохицуулагч Серж Малколм Йорк хэлэхдээ “Хосын сэтгэл санаа сайн байсан ч сүүлийн 10 хоног хоол идээгүй байсныг тогтоосон” хэмээн ярьжээ. Сонирхуулахад, Кахуранжийн үндэсний цэцэрлэгт хүрээлэн нь газар нутгийн хэмжээгээрээ Шинэ Зеландад хоёрдугаарт ордог аж. ■

Улаан сайдын уршиг хийгээд ноолуур тойрсон дампуу

Ганц малчин 90 ямаа илүү тоолуулж, 600 мянган төгрөг улсаас “тоншиж” байна гээд бод доо. Цаана нь түүн шиг зальжин нөхөр хэд байгааг таашгүй

Э.Энхлүүн, ЗГМ сонин

Улайдаггүй Ч.Улаан сайд өнгөрсөн сард “Килограмм ноолуурыг 100 мянган төгрөгөөр авна. Би худлаа яриагүй. Энэ ажлыг хар толгойгоороо хариуцна” гэж сүржин мэдэгдсэн. Тус мэдэгдэл малчдын магнайг хэсэгхэн хугацаанд тэнийлгэсэн ч, удалгүй хоосон үг болж хувиран тэднийг багагүй бухимдуулав. Сонгуулийн өмнө ингэж оноо алдах нь эрх баригчдад ашиггүй тул гэмээ цайруулж, тал засахын тулд килограмм ноолуур тутамд 20 мянган төгрөгийн урамшуулал олгохоор болсон билээ. Гэвч “ямааны 20 мянга” тойрсон жинхэнэ дампуу үйл явдлууд одоо л дөнгөж өрнөж эхэлж байна.

ИШИГ, СЭРХ ЯЛГАЛГҮЙ ГУРВАН ЯМАА ТУТАМД 20 МЯНГАН ТӨГРӨГ ӨГЧ БАЙНА

Нэг килограмм ноолуур тутамд 20 мянган төгрөг олгох шийдвэр өчигдрөөс ажил хэрэг болж, мал бүхий иргэдийн дансанд бэлэн мөнгө цутгаж эхлэв. Гэхдээ сонгуулиас урьтаад бэлэн мөнгө тарааж, малчдаас оноо цуглуулах гэж хэт яарсан нь иргэдийг башийлгаж, улсын төсвийг хоослох эрсдэл бий болголоо. Ноолуурын энэхүү урамшуулалд 200 орчим тэрбум төгрөг зарцуулж байгаа бөгөөд хэний хотноос хэдэн килограмм ноолуур гарч байгаагаас үл хамаарч, ишиг, эр ямаа гэж ялгалгүй малынх нь тоогоор мөнгө олгож

Сонгуулиас урьтаад бэлэн мөнгө тарааж, малчдаас оноо цуглуулах гэж хэт яарсан нь иргэдийг башийлгаж, улсын төсвийг хоослох эрсдэл бий болголоо. Ноолуурын урамшуулалд 200 орчим тэрбум төгрөг зарцуулж байгаа бөгөөд хэний хотноос хэдэн килограмм ноолуур гарч байгаагаас үл хамааран мөнгө олгож эхэлжээ.




Тушаасан нэг килограмм ноолуур тутамд 20 мянган төгрөгийн урамшууллыг малчдад олгохоор анх шийдвэрлэсэн. Гэтэл ажил болж хэрэгжихдээ, гурван ямаа тутамд 20 мянган төгрөг болон өөрчлөгджээ.

эхэлжээ. Уг нь анх малчдаа дэмжих нэрийн дор тогтоолын төсөл боловсруулахдаа, ноолуурын зах зээлийн суурь үнэ дээр нэмж, тушаасан нэг килограмм ноолуур тутамд 20 мянган төгрөгийн урамшууллыг малчин өрх бүрт олгохоор шийдвэрлэсэн. Гэтэл ажил болж хэрэгжихдээ нэг ямаанаас 300 грамм ноолуур гарна гэж тооцоолоод, гурван ямаа тутамд 20 мянган төгрөг олгож

орчим грамм байдаг. Эм ямаа сүргийн дунжийг илтгэдэг гэж үздэг учраас ингэж шийдвэрлэх нь зүйтэй гэж манай зөвлөлөөс Засгийн Газарт зөвлөмж өгсөн” гэж тайлбарласан юм.

МАЛАА НЭМЖ ТООЛУУЛСАН ИРГЭДЭД ХЯНАЛТ ТАВИХ ТОГТОЛЦОО АЛГА

Үүнээс гадна, мал тооллогын үеэр ямааны тоогоо нэмж бүртгүүлсэн иргэдэд хяналт тавилгүй улсын мөнгийг цацаж буй нь баримтаар ил болж эхэллээ. Дансанд нь төсөөлж, тооцоолж байснаас их мөнгө орсонд баярласан нэг иргэн “Малчны зээл авах санаатай ямаагаа ахиу тоолуулсан нь зол боллоо. Уг нь би 60 ямаатай хүн. Гэхдээ энэ жилийн тооллогоор 150 ямаатай гээд бүртгүүлчихсэн юм. Ноолуур тушааж, түүнээсээ урамшуулал авсан бол гавьтай мөнгө ирэхгүй нь гэж бодож байлаа. Тэгсэн өнөөдөр дансанд маань сая гаруй төгрөг “ноолуурын урамшуулал” гээд орчихсон байна. Тоолуулсан ямаа бүхэнд мөнгө өгч байгаа бололтой. Манай нутагт ямаагаа самнасан айл байхгүй ч бүгд ноолуурын урамшууллаа түрүүлж аваад башийж байна” гээд баярлан яриулав. Ямаагаа ахиу тоолуулсан нь хяналтгүй төрийн “гавьяагаар” хожиж буйг эндээс харж болно. Ганц малчин 90 ямаа



илүү тоолуулж, 600 мянган төгрөг илүү “тоншиж” байна гээд бод доо. Цаана нь түүн шиг зальжин нөхөр хэд байгааг таашгүй.

[ЗГМ СОНИН]

“Засгийн газрын мэдээ” сонин нь ардчилсан, шударга ёс, хүний эрхийг дээдэлж, чөлөөт сэтгүүл зүйн хэм хэмжээг бүрнээ сахин, олон ургальч үзлийг илэрхийлэх мэдээллийн индэр байж, нийт Монгол үндэстний ойлголцол, эв нэгдлийг бэхжүүлэхийг эрхэм зорилгоо болгоно.

ТУЗ-ийн дарга
Эрдэнэбаатарын **ДОЛГИОН**
Ерөнхий эрхлэгч
Баатарын Дуламхорлоо
Зөвлөх
Шатарбалын Даваадорж
Орлогч эрхлэгч
Лхагважавын Сугармаа
Утас: 99903584

РЕДАКЦ

Улс төр, нийгэм, эрэн сурвалжлах мэдээллийн алба
Эдитор Б.Энхжаргал
Утас: 99901621
Эдийн засаг, уул уурхайн мэдээллийн алба
Эдитор Б.Баяртогтох
Утас: 99901532
Цахим контент, бүтээлч үйлдвэрлэлийн алба
Эдитор Г.Баярсайхан
Утас: 99903574

ЗАР СУРТАЛЧИЛГАА

Утас: 99903581
99903578
99907843
ЦАХИМ ХУВИЛБАР
zgm.mn
ubinfo.mn

ХАЯГ

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
I хороо, Энхтайваны өргөн чөлөө,
“Блю Скай тауэр” 407 тоот
Улсын бүртгэлийн дугаар. 1024
Утас: 70103131,
Факс: 70106065

ДУГААРЫН УДИРДАГЧ

Г.Баярсайхан
ТОДРУУЛГА & ЗАЛРУУЛГА
Уншигч та манай сонины мэдээ, нийтлэл, сурвалжилгатай холбоотой тодруулж, залруулах шаардлагатай санал, хүсэлт байвал
INFO@ZASAG.CO
Утас: 99903584 хаягаар бидэнтэй холбогдоно уу.



Гэрэл зургийг С.Батсайхан

ТӨРИЙН БУЯН ГЭЭД БАЯРЛАЖ СУУГАА ТҮМЭНД СОНГУУЛИЙН ДАРАА ТӨР ТӨМӨР НҮҮРЭЭ ҮЗҮҮЛЭХ НЬ

Өөрт байхгүй малыг илүү тоолуулж, улсаас урамшууллын мөнгө авч байгаа хүмүүст хяналт тавьж байгаа эсэхийг болон энэ асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар холбогдох яамнаас тодруулахад “Хэрэв илүү мал тоолуулсан нь нотлогдох юм бол эрүүгийн хариуцлага тооцож, мөнгийг нь буцааж татна. Шалгалтын ажил жилийн хугацаанд үргэлжилнэ. Тэгэхээр илүү тоолуулсан мал нь илэрч л таараа” гэсэн хариу өгөв. Төрийн буян хэмээн баярлаж суугаа түмэнд сонгуулийн дараа төр төмөр нүүрээ үзүүлэхээр

ИРГЭДИЙН ДАНС РУУ МӨНГӨ ШИЛЖҮҮЛЭХЭЭСЭЭ ӨМНӨ ХЯНАЛТ, ШАЛГАЛТ ХИЙГЭЭГҮЙН УЧИР, ШАЛТГААНЫГ ЛАВЛАХАД “АЙЛ БҮРИЙН ЯМААГ ТООЛООД ЯВБАЛ ИРГЭДИЙН ДАНСАНД ЭНЭ ОНДОО БАГТАЖ МӨНГӨ ОРОХГҮЙ ШҮҮ Ч ҮГҮЙ ХАРИУЛАВ.

зэхэж буй нь дээрх тайлбараас харагдлаа. Иргэдийн данс руу мөнгө шилжүүлэхээсээ өмнө хя-

налт, шалгалт хийгээгүйн учир, шалтгааныг лавлахад “айл бүхний ямааг тоолоод явбал иргэдийн дансанд энэ ондоо багтаж мөнгө орохгүй шүү дээ” хэмээн хэнэг ч үгүй хариулсан юм.

Улсын мөнгийг тооцоо судалгаагүй тарааж, төрийн буянаар түмнээ ивээж байна хэмээн попорч байгаад учир бий. Сонгуулиас өмнө малчдын ая талыг засах гэсэндээ мөнгө тараах хамгийн хялбар аргыг, богино хугацаанд сүвэгчилжээ. Гэхдээ малын тоогоо худал мэдүүлж, урамшууллын мөнгө авсан нь төрийн хишиг хэмээн баярлаж суугаа түмэн сонгуулийн дараа хуулийн хариуцлага хүлээж, “дээлээ нөмөрч” ч мэдэх нөхцөл байдалд оржээ. ■

ЗГМ: ТОДРУУЛГА

Б.Батхүү: Илүү мал тоолуулсан нь илэрвэл мөнгөө буцааж татна

Ноолуурын урамшууллыг малчдад өгөхдөө ямар судалгаа, мэдээлэл дээр үндэслэж байгаа болон малаа худлаа тоолуулж, урамшуулалд хамрагдсан иргэдэд ямар арга хэмжээ авах талаар ХХААХҮЯ-ны Хөнгөн үйлдвэрийн бодлого зохицуулалтын газрын дарга Б.Батхүүгээс тодрууллаа.

үндэслэсэн үү?

-Малчин бүхэнд А данс гэж бий. Тус дансанд хэчнээн ямаа тоолуулснаар нь тооцоолж олгож байна. Өөрөөр хэлбэл, 2019 оны жилийн эцсийн мал тооллогын дүн дээр үндэслэсэн.

-Мал тооллогын үеэр малаа ахиу тоолуулсан иргэд өөрт байхгүй малаас ашиг хүртэж байна. Үүнийг хянахгүй мөнгө тарааж буй нь учир дутагдалтай биш үү?

-Сум бүхэнд хөдөө аж ахуйн тасаг гэж бий. Тус тасгийн мэргэжилтэн сумандаа байгаа малчны хэдэн малтайг мэддэг. Тэд малчдын малын тоонд хяналт тавьж, баталгаажуулаад бидэнд ирүүлдэг. Тамга тэмдэг бүхий ийм бичиг дээр л үндэслэх ёстой шүү дээ. Сумандаа хяналт тавих үүрэгтэй ажиллаж байгаа болохоор малчид малаа илүү тоолуулсан бол хариуцлага нь сумын хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн дээр тооцогдоно.

-Зөвхөн сумын мэргэжилтний ирүүлсэн судалгаан дээр үндэслэж мөнгө олгох нь учир дутагдалтай биш үү. Үнэн зөв мэдүүлсэн эсэх дээр нь хяналт тавьж ажиллах тогтолцоо байдаггүй юм уу?

-Хэрэв тухайн мэргэжилтэн танил талынхаа малыг илүү тоолуулсан, эсвэл хариуцлагагүй ажилласан нь илэрвэл хуулийн хариуцлага тооцно. Мөнгө олгоод л орчихгүй, жилийн турш хяналт шалгалт хийнэ. Санхүүгийн аудитаар шалгалт хийхээр хэн хэчнээн мал илүү тоолуулсан нь илэрнэ. Илэрсэн тохиолдолд мөнгөө буцааж шилжүүлэн, улсыг хохиролгүй болгоно. Хуулийн хариуцлага ч хүлээлгэнэ. ■



-Тушаасан нэг килограмм ноолуур тутамд 20 мянган төгрөгийн урамшуулал өгөхөөр анх тогтоолын төсөл боловсруулсан шүү дээ. Гэтэл өчигдөрөөс ямааны тоогоор нь тооцоолж, мөнгө олгож эхэлсэн байна. Ямар тооцоо судалгаа дээр үндэслэж ингэж шийдсэн юм бэ?

-Ямааны ашиг шимийн орон тооны бус зөвлөл гэж бий. Тус зөвлөлөөс ноолуурын урамшууллыг ямар стандартаар, яаж олгох тухай зөвлөмж өгсөн. Уг зөвлөмжийн дагуу ажиллаж байна. Ингэхдээ зүүн аймгийн ноолуур сайн чанартай, баруун аймгийнх бүдүүн ширхэгтэй гэж ялгахгүй бүгдийг нь дундажлаад мөнгө олгож байна. Уг нь борлонгоос 150 орчим грамм, эр ямаанаас килограмм орчим ноолуур гардаг. Гэхдээ яг ингэж нарийн тооцох юм бол урамшууллын мөнгийг энэ жилдээ олгож чадахгүйд хүрнэ. Тиймээс ишиг, борлонгийн ноолуурыг ч 300 граммаар, эр ямааныхыг ч 300 граммаар тооцоолсон.

-Хэн хэчнээн ямаатайг мал тооллогын дүн дээр

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2020.05.29

Тендер шалгаруулалтын нэр: **Барилга байгууламжийн их засварын ажил гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах.**
Тендер шалгаруулалтын дугаар/гэрээний дугаар: **УСУГ-АУ-2020-89**

Ус сувгийн удирдах газар эрх бүхий тендерт оролцогчдоос **Барилга байгууламжийн их засварын ажил гүйцэтгэгчийг** сонгон шалгаруулах тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна. Тухайн тендерт эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр 50,000 /тавин мянган/ төгрөгний цахим тендерийн хураамж төлж оролцоно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 30 хоногийн дотор хүчинтэй байна. Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
-Сүүлийн 2 жил буюу 2018, 2019 он тус бүрийн Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлнэ.
-Сүүлийн 2 жилд буюу 2018, 2019 он тус бүрт ижил төстэй гэрээ хийсэн тухай мэдээлэл ирүүлнэ.
-Борлуулалтын орлого нь сүүлийн 2 жил буюу 2018, 2019 он тус бүр тухайн багцын төсөвт өртөгөөс 100%-с дээш байх.
-Тендерийн хамт

- Багц-1 600,000 /зургаан зуун мянган/ төгрөг,
- Багц-3 600,000 /зургаан зуун мянган/ төгрөг,
- Багц-4 630,000 /зургаан зуун гучин мянган/ төгрөг,
- Багц-5 630,000 /зургаан зуун гучин мянган/ төгрөг,
- Багц-6 800,000 /найман зуун мянган/ төгрөг,
- Багц-7 500,000 /таван зуун мянган/ төгрөгний тендерийн баталгаа тус тус ирүүлнэ.

-Хүчинтэй байх хугацаа: 2020 оны 8 дугаар сарын 26-ны өдрийг дуустал.
Тендерийг **2020 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн 10 цаг 00 минутаас** өмнө цахим системээр тендерийн материалаа ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2020 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн 10 цаг 30 минут**-аас нээнэ. Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно. Дотоодын давуу эрх тооцно. Гадаадын этгээд оролцох эрхгүй.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Ус Сувгийн Удирдах газар, Токиогийн гудамж-5, өөрийн байр, Б.Лхагвасүрэн Утас: 70157018-125

Г.Санжааханд, ЗГМ сонин

Удахгүй теле хичээл дуусаж, сурагчдын амралт албан ёсоор эхэлнэ. Зуны амралтыг нь үр бүтээлтэй өнгөрүүлэхийн тулд эцэг, эхчүүд хүүхдээ зусланд амраадаг. Тэгвэл энэ жил коронавирус гарсантай холбоотойгоор хүүхдийн зуслан ажиллах эсэхийг нийслэлийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дарга Н.Мандуулаас тодрууллаа.



-COVID-19-ийн цар тахлаас болж хөл хорио тогтоосон энэ үед хүүхдийн зуслангууд ямар журмаар ажиллах вэ?

-УОК-ын шийдвэрээр хорио цээрийн дэглэмийг ирэх сарын 30-ны өдөр хүртэл сунгасан. Цаашид дэглэм сунгахгүй бол хүүхдийн зуслангууд хэвийн ажиллаж болно. Нийслэлийн ногоон бүсэд үйл ажиллагаа явуулдаг 20 зуслан хүүхдүүдээ авах бэлтгэлээ хангаад эхэлсэн. УОК-ын шийдвэр яаж гарахаас шалтгаалж энэ зун хүүхдийн зуслан ажиллах, эсэх шийд гарна.

-Хөл хорионоос болж зусланд амрах хүүхдүүдийг эцэг, эхтэй нь хамт амраана гэх мэдээлэл гарсан байсан. Энэ үнэн үү?

-Монголын зуслангийн холбоотой ярилцаад гэр бүлээр нь амраах үйлчилгээг санал болгохоор болсон. Хөл хорионы үед Эрүүл мэндийн сайдын тушаалаар халдвар хамгааллын дэглэмийг баталсан. Үүний дагуу ажиллахад багагүй хүндрэл учирч байгаа. Тухайлбал, хүмүүсийг олноор нь цуглуулахгүй, уралдаан тэмцээн зохион байгуулахгүй байх шаардлага тавьсан. Энэхүү шаардлага нь хүүхдийн зуслангийн үндсэн үйл ажиллагааг шууд өөрчлөхтэй холбоотой учир ажиллах боломжгүй болчихоод байгаа юм. Тиймээс хорио цээ-

Н.Мандуул: Хүүхдүүдийг зусланд эцэг, эхтэй нь хамт амраах санал дэвшүүлсэн

Хүүхдийн зуслангийн үйл ажиллагааг гэр бүлийн амралтын зориулалтаар ажиллуулъя гэж ярилцаж байна



Гэрэл зургийг Ж.Гэрэлчулуун

ХҮҮХДҮҮД 7-10 ХОНОГИЙН ХУГАЦААНД ЗУСЛАНД АМАРДАГ. ЭНЭ ХУГАЦААНД ЭЭЖ, ААВТАЙГАА ХАМТ ОЛОН ХҮНТЭЙ УУЛЗАЖ, БӨӨГНӨРӨЛ ҮҮСГЭХГҮЙГЭЭР АМРАХ БОЛОМЖТОЙ.

рийн дэглэм суларсан эсвэл цуцалсан тохиолдолд хүүхдийн зуслангууд хэвийн үйл ажиллагаа явуулна гэсэн үг.

-Яагаад эцэг, эхтэй нь хамт амраах саналыг дэвшүүлсэн юм бэ?

-Хүүхдийн зуслангийн үйл ажиллагааг гэр бүлийн амралтын зориулалтаар ажиллуулъя гэж ярилцаж байна. Эрүүл мэндийн сайдын гаргасан нийтлэг болон тусгай шаардлагаар гэр бүлийн зориулалттай бол үйл ажиллагаа явуулж болно гэсэн. Хүүхдүүд 7-10 хоногийн хугацаанд зусланд амардаг. Энэ хугацаанд ээж,

аавтайгаа хамт олон хүнтэй уулзаж, бөөгнөрөл үүсгэхгүйгээр амрах боломжтой. Гэхдээ энэ зөвхөн санал төдий зүйл. Уг саналыг боловсруулж дуусаад УОК-т танилцуулна. Тус комиссоос тодорхой шийдвэр гаргах ёстой.

-Хүүхдийн зусланд хэчнээн хүүхэд явдаг вэ. Энэ жил хүүхдээ зуслан явуулах сонирхолтой эцэг, эхч хэр олон байгаа бол?

-Өнгөрсөн жил 24450 хүүхэд зусланд амарсан. Энэ жилийн хувьд энэ тоо хоёр дахин багасах магадлал бий. Коронавирусийн халдвартай холбогдуулаад бид тандалт судалгаа хийсэн. Эцэг, эхчүүдийн хувьд өмнөх жилүүд шиг өндөр хүлээлт, дараалал байхгүй болсон байна. Хүүхдийн зусланг нээлээ гэхэд ор хоорондын зай хоёр метрээс доошгүй байна гэвэл "Найрамдал" зуслангийн хамгийн том өрөөнд дөрвөн хүүхэд байх болно. Харин бусад зуслангуудад 1-2 хүүхэд хамт байх боломж-

той. Хүүхдийн зусланд зургадугаар сарын 1-нээс наймдугаар сарын 25 хүртэл 10 ээлж авна гэхээр хүүхдийн тоо багасах нь тодорхой. Мөн халдвар хамгааллын дэглэм баримтлахад тодорхой зардал гарна. Энэ зардлаа дараа нь нөхөж чадах эсэх нь эргэлзээтэй. Учир нь хүүхдийн зуслангийн үнэ 180-380 мянган төгрөгийн хооронд байдаг. ■

ЗГМ: ТОВЧХОН

■ АНХААРУУЛГА

НМХГ-аас Эх үрсийн баярыг угтсан хяналт шалгалтын үеэр хугацаа нь дууссан хүнсний бүтээгдэхүүн худалдаж байсныг хурааж авсан байна. Тиймээс хүүхдийн бэлгийн орцод орсон хүнсний бүтээгдэхүүний хадгалалтын хугацаа, сав баглаа боодлын бүрэн бүтэн байдлыг сайтар шалгаж худалдан авалт хийхийг эцэг, эхчүүдэд анхаарууллаа.

■ ЗӨРЧИЛ

Нийслэл хотоос зүүн тийш гарч буй зам тээврийн ослын дийлэнхийг хурдаа зөв тохируулан оролцож чадаагүй болон гүйцэж түрүүлэх үйлдлийг буруу хийснээс гарсан осол эзэлж байгаа аж. Тиймээс Хонхор, Дүнжингарав худалдааны төв, Гачуурт болон Улиастайн замд 24 цагаар эргүүл хийж, хурдны зөрчил илрүүлэх зургаан ширхэг зөөврийн төхөөрөмжийг байрлуулан зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж байна.

■ ЗАМ ЗАСВАР

Нийслэлийн АЗХГ-ын захиалгаар Нийслэлийн авто замын сүлжээний гудамж, замуудын арчлалтын ажлын хүрээнд Чингэлтэй дүүргийн Гүнтийн давааны 2.1 км авто замыг хусаж тэгшлэх, нягтруулах ажлыг энэ сарын 21-26-ны хооронд "Улаанбаатар зам, засвар арчлалтын газар" ОНӨААТҮГ гүйцэтгэж дуусгасан байна.

ТЕНДЕРИЙН УРИЛГЫН ЗАЛРУУЛГА

Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газраас 2020 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн "Засгийн газрын мэдээ" сонины №069(1348) дугаарт зарлагдсан **Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй Соёлын ордны барилга 850 хүний суудалтай /НД/** ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн баримт бичигт дараах өөрчлөлтийг оруулж байна.

Тендерийн баримт бичгийн ТООЗ 23.1, 26.1-т **"Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь: Огноо: 2020 оны 05 дугаар сарын 29-ний өдөр, Цаг: 09 цаг 10 минут, Тендерийн нээлт хийх хугацаа: Огноо: 2020 оны 05 дугаар сарын 29-ний өдөр, Цаг: 09 цаг 20 минут"** гэснийг **"Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь: Огноо: 2020 оны 06 дугаар сарын 08-ны өдөр, Цаг: 09 цаг 10 минут, Тендерийн нээлт хийх хугацаа: Огноо: 2020 оны 06 дугаар сарын 08-ны өдөр, Цаг: 09 цаг 20 минут"** гэж, тендерийн нээлтийн хугацааг хойшлуулсантай холбогдуулан **"тендерийн баталгааны хүчинтэй байх хугацаа 2020 оны 07 дугаар сарын 23-ны өдөр"** гэснийг **тендерийн баталгааны хүчинтэй байх хугацаа 2020 оны 08 дугаар сарын 05-ны өдөр"** болгон өөрчилж байна.

Залруулгын талаархи болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, Бага тойруу -15, Нийслэлийн Засаг захиргааны 4 дүгээр байр, 10 дугаар давхар, Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар, Утас: 75757810

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

13 хүнээс коронавирусийн халдвар илэрч, нийт тохиолдол 161 боллоо

Энэ сарын 27-ны өдөр улсын хэмжээнд нийт 517 хүнд шинжилгээ хийхэд 13 хүнээс коронавирус илэрсэн болохыг ХӨСҮТ-ийн ерөнхий захирал Д.Нямхүү хэллээ. Тэдний 12 нь тухайн өдөр Алтанбулаг боомтоор ирсэн хүмүүс аж. Харин үлдсэн нэг нь мягмар гарагт Москва-Улаанбаатар

чиглэлийн онгоцоор ирсэн оюутан бөгөөд давтан шинжилгээгээр коронавирустэй болох нь тогтоогджээ. "ОХУ-д байсан оюутнууд маш их халдвар авсан нь харагдаж байна.

Хүний нутагт голдуу 17-20 насны хүүхдүүд байгаа. Эдгээр хүүхдүүдийг эцэг эх, ах дүү нарынх нь дэргэд, эх оронд

нь эмчилж байгаа маань маш сайхан хэрэг боллоо" хэмээн Д.Нямхүү захирал хэлсэн юм. Ийнхүү коронавирусийн нийт тохиолдлын тоо 161 болж нэмэгдсэн ч эдгэрсэн хүний тоо 43 боллоо. Одоогийн байдлаар эмчилгээ хийлгэж байгаа 107 хүний биеийн байдал хөнгөн, 11-ийх нь хүндэвтэр байгаа аж.

НИЙТЛЭЛЧИЙН БУЛАН

Хууль, шүүхийн байгууллагынхан сонгуульд зориулж эрх баригчдад үйлчилж байна гэх хардлагыг төрийн байгууллагууд баяжуулж байна

Б.Гарьд, ЗГМ Сонин

Сонгуулийн жилийн эхнээс хууль, хяналтын байгууллагын үйл ажиллагаа идэвхжиж, улстөрчидтэй холбоотой хэргүүд ээлж дараалан шүүхийн шатанд овоорлоо. Тэр дундаа АН-ын угшилтай улстөрчдийн нэр холбогдсон хэргүүд шүүхээр ээлж дараалан хэлэлцэгдэж буй нь эрх баригчдад үйлчилж байна гэх хардлагыг улам лавшруулж байгаа юм. Үүнээс гадна эрх баригчдад далдуур үйлчилж эхэлсэн гэх хардлагыг зарим төрийн байгууллагын үйл ажиллагаа улам баяжуулж буйг баримтаар дурдъя.

Нэгэн жишээ: Манай сонин саяхан статистикийн байгууллага эрх баригчдад илт “тал зассан” худал мэдээлэл гаргасныг тоо баримтаар ил болгосон. Тус нийтлэлд иргэдийг бодит мэдээллээр хангах байгууллага эрх баригчдад “долигонож” олны элэг доог болж буйг ч өгүүлсэн юм. **Үндэсний статистикийн хорооноос мэдээлсэн итгэхэд бэрх үзүүлэлтээс дурдвал, өрхийн орлого 248 мянган төгрөгөөр нэмэгдсэн, ажилгүй иргэдийн тоо 1800-гаар буурсан, ресторануудын орлого 1.3 тэрбум төгрөгөөс өссөн, аж үйлдвэрлэл 6.4 хувиар өгссөн, бөөний худалдаа 6.3 тэрбумаар тэлсэн гэжээ.** Цар тахлын улмаар эдийн засаг агшиж, үйлдвэрлэл хумигдаж, худалдааны эргэлт царцан, иргэдийн амьжиргаа, өрхийн орлого огцом буураад байгааг хэн хүнгүй мэдэж байхад илт зөрүүтэй мэдээлэл түгээсний цаана эрх баригчдыг харлуулахгүй гэсэн санаа агуулагдаж байна гэж хардахаас аргагүй.

Нэгэн жишээ: ШӨХТГ-ын дарга өнгөрсөн сарын 20-нд “Бүх ШТС-д шатахууны чанар, дүүргэлт, дутуу шахалтад гэнэтийн шалгалт хийж, дээж аван, төв лабораториор шинжлүүлж хариуг нь долоо хоногийн дотор албан ёсоор мэдээлнэ” гэсэн боловч таг чиг болсон. Харин өчигдөр мэдээлэхдээ “Хяналт шалгалтын ажлыг 30 хоногоор сунгасан, шалгалт үргэлжилж байна. Шатахуун бол улсын стратегийн чухал бүтээгдэхүүн учраас ултай, суурьтай судалж, дүн мэдээллийг дэлгэнэ” гэсэн тайлбар мэдэгдэл хийв. **Долоо хоногт албан ёсны хариу нь гарна гэж бардам мэдэгдэж байсан төрийн байгууллагын удирдлага шалгалтын ажлын хугацааг**



Гэрэл зургийг Ж.Гэрэлчулуун

Төрийн байгууллагууд эрх баригчдыг “долоож”, бодит байдлыг нууж эхлэв

сунгах, үргэлжилж байна гэж мэдээлэхийн учрыг иргэд, олон нийт сайн ойлгосонгүй. Эндээс сонгуультай холбоотойгоор нийгэмд “доргио” үүсгэхгүй байхаар тооцож, хугацааг нь сунгасан юм биш биз гэх хардлага эрхгүй төрж байгаа юм.

Нэгэн жишээ: Олон нийтийн өмнө ил тод, шударга байх ёстой АТГ эрх баригчдын хөрөнгө орлогын мэдүүлгийг (ХОМ) зарлахгүй удаж байгаа нь тэдэнд үйлчилж байна гэх хардлагыг шууд төрүүлнэ. **Өмнөх жилүүдэд АТГ төрийн болон төрийн өндөр албан тушаалтнуудын ХОМ-ийг аль дөрөвдүгээр сарын эхээр зарлачихдаг байсан ч энэ удаа сунжруулж дарсан нь хардлагыг улам лавшруулаад байгаа юм.** Хуулиараа жилийн хоёрдугаар улиралд багтаан нийтэд ил болох ёстой ч энэ удаад улирлын төгсгөлд буюу сонгуулийн сурталчилгаа дууссаны дараа зарлах мэдээлэл ч “чих дэлсэж” байгаа нь яах аргагүй эрх баригчдад үйлчилж байна гэсэн хардлага руу хөтөллөө. Нөгөөтэйгүүр энэ нь өмнөх жилүүдийн уламжлалаас “гажсан” шударга бус байдлыг далдуур бий болгож байгаа юм.

Нэгэн жишээ: Өндөржүүлсэн бэлэн байдлын дэглэмийн хугацааг удаа, дараа сунгаж байгааг талархан хүлээж авч буй иргэн олон ч нөгөө талд нь эрх баригчид улс төрийн эсэргүүцэл жагсаал цуглаанаас “жийрхэх”-дээ байдлыг далимдуулж байна хэмээн хардаж буй хүн ч цөөнгүй

бий. Хорио цээрийн дэглэмийн улмаас зарим сөрөг үр дагавар нэмэгдсэнийг ч тэд шүүмжилж байгаа. Тухайлбал, ахуйн хүрээний архидалд нэмэгдэж, гэр бүлийн хүчирхийллийн тоо

өссөнийг цагдаагийн байгууллага “зөөллөж” байна гэх хардлага газар авав. Үүнийг батлах мэт төрийн байгууллагуудын тоо баримт зөрж эхэллээ. **Статистикийн байгууллагаас**

хийсэн судалгаанд “2020 оны эхний улиралд гэр бүлийн хүчирхийллийн 3131 гэмт хэрэг, зөрчил шалгагдаж, 2244-ийг нь шийдвэрлэсэн. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал, гэр бүлийн хүчирхийллийн улмаас үүдсэн зөрчил 61.6 хувиар өсжээ” гэсэн. Гэтэл ЦЕГ-ын статистик мэдээлэлд эхний гурван сарын байдлаар гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг 27 бүртгэгдэж өмнөх оныхоос 133 хэргээр буюу 83.6 хувиар буурсан гэжээ. Илт зөрүүтэй энэ мэдээллийн цаана цагдаагийн байгууллага эрх баригчдын цар тахлын үед авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээг харлуулахгүй гэсэн санаа явж байгаа юм биш биз гэсэн хардлагыг төрүүлж байна.

Дээрх жишээ, тоо баримтаас дүгнэхэд төрийн байгууллагууд сонгууль угтсан “кампанит ажилд” хүчин зүтгэж эхэлсэн гэх хардлага эрхгүй төрж байна. Хардахаас илүү харагдаж байгаа байдал нь төрийн байгууллагууд үнэн мэдээлэлд дулдуйддаг болов уу гэсэн эргэлзээ лавшрууллаа. Чухам энэ эргэлзээ сонгуулийн дараа батлагдвал ард түмнээ хуурсан хэрэгт МАН-ын эрх баригчид төдийгүй төрийн байгууллагууд хэлхэгдэж, муу нэрээ улам шаварт хутгах вий. ■



ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНКНЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

Компанийн оноосон нэр, хаяг:

Худалдаа, хөгжлийн банк ХХК

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Энхтайваны өргөн чөлөө 19, 14210, Худалдаа, хөгжлийн банкны төв байр

Хурал хуралдуулах газар, өдөр, цаг:

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2020 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 10:00 цагт Монгол Улс, Улаанбаатар хот 14210, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Энхтайваны өргөн чөлөө 19 хаягт орших Худалдаа, хөгжлийн банкны байранд цахим хэлбэрээр хуралдуулна.

Хурлаар хэлэлцэх асуудал:

1. Худалдаа, хөгжлийн банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх;
2. Худалдаа, хөгжлийн банкны дүрэмд өөрчлөлт оруулах;
3. Бусад асуудал.

Хуралд бэлтгэх явцад хувьцаа эзэмшигч холбогдох баримт бичигтэй танилцах журам:

Хувьцаа эзэмшигч та Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой баримт бичигтэй 2020 оны 6 дугаар сарын 8-ны өдрийн 09:30 цаг хүртэл Монгол Улс, Улаанбаатар хот 14210, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Энхтайваны өргөн чөлөө 19 хаягт хүрэлцэн ирж танилцах боломжтой.

Хуралд цахимаар оролцох боломжгүй хувьцаа эзэмшигчдийн саналыг саналын хуудсаар 2020 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 09:30 цаг хүртэл Монгол Улс, Улаанбаатар хот 14210, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Энхтайваны өргөн чөлөө 19 хаягт орших Худалдаа, хөгжлийн банкны байранд хүлээн авна.

Энэхүү Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралтай холбоотой бусад мэдээллийг дараах хаягаар холбоо барьж лавлана уу.

Худалдаа, хөгжлийн банкны ТУЗ-ийн нарийн бичгийн дарга: Ө.Батчимэг

Утас/Факс: (976)-11-328227

Гар утас: (976)-80083993

Электрон шуудангийн хаяг: batchimeg.u@tdbm.mn

2020.05.29

ЭДИЙН ЗАСАГ

☉ Эрүүл мэндийг хамгаалахын зэрэгцээ эдийн засагтаа анхаарах шаардлагатай



➔ 10

☉ Өмнөд Хятадын тэнгис дэх сэргөлдөөний эрсдэл нэмэгдэж байна

➔ 11

☉ Өмнөд Солонгос бодлогын хүүгээ түүхэн доод хэмжээ рүү буулгав

➔ 11

ЗГМ: ТОВЧХОН

■ АРИЛЖАА

Монголын хөрөнгийн бирж пүрэв гарагийн үнэт цаасны арилжаагаар 17 компанийн 7,693,429 ширхэг хувьцаа арилжлаа. Энэ өдөр долоон компанийн хувьцааны ханш өсөж, таван компанийнх буурав.

■ ИНДЕКС

0.14

Хувь. ТОП 20 индекс 0.14 хувиар буурч, зах зээлийн үнэлгээ 2.4 их наяд төгрөг боллоо.

■ ДУУДЛАГА ХУДАЛДАА

49.2

Сая ам.доллар. Төв банк гадаад валютын дуудлага худалдаагаар зах зээлд 49.2 сая ам.доллар нийлүүлээ.

■ СТАТИСТИК

60.8

Хувь. Нийтийн хоолны салбарын орлогын 60.8 хувийг ресторан, 24.6 хувийг захиалгат хоолны хүргэлтийн үйлчилгээ, 6.9 хувийг кафе, зургаан хувийг гуанз, 1.7 хувийг баарны үйл ажиллагааны орлого эзэлж байна.

■ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

35.3

Тэрбум төгрөг. Зочид буудлын салбарын орлого 2020 оны эхний улиралд 35.3 тэрбум төгрөг болж, өмнөх улирлаас 44.9 тэрбум төгрөгөөр буурсан байна.

■ ДААТГАЛ

40.7

Тэрбум төгрөг. Даатгалын хураамжийн орлого оны эхний улиралд 40.7 тэрбум төгрөгт хүрэв.

■ ӨРХИЙН ТӨСӨВ

12.6

Хувь. Үндэсний статистикийн хорооны мэдээлснээр, өрхийн сарын дундаж орлогын хэмжээ 2020 оны эхний улиралд 1.2 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 12.6 хувиар өсөв.

✍ Б.Мөнх-Эрдэнэ, ЗГМ сонин

Төгрөгтэй харьцах ам.долларын ханш огцом өсөж байгааг үнэндээ гайхах хэрэггүй.

Гадаадын шууд хөрөнгө оруулалт буурч эхэлсэн цагаас хойш төгрөгийн ханш суларч, Монголын “зовлон” эхэлсэн. Төв банк валютын нөөцөө шавхаж, дэлхийн эдийн засгаас улсаараа “шанаа” хүртэх нөхцөл ингэж бүрдсэн. Үүнд улстөрчдийн үүрэг, оролцоо хамгийн их байлаа. Тэд эх оронч дүр бүтээх тусам монгол төгрөгийн ханш түүхэнд байгаагүйгээр унаж байв.

Нүүрсний экспорт тасалдаж, “Оюутолгой”-н төслийн хөрөнгө оруулалт удаахрахтай зэрэгцэн эдийн засгийн өсөлт уруудсан. Энэ хэрээр өсвийн орлого хамт тасрав. Цалин, тэтгэвэр тэтгэмж нэмэх боломжоо манай улс давхар алдлаа. Хөрөнгө оруулагчдыг гадуурхаж, тэднийг хараан зүхэх тусам эдийн засаг дордож, ам.долларын ханшийн савлагаа нэмэгдсэн билээ. Эдгээр нь бидний араншин болжээ. Монголд хөрөнгө оруулалт орж ирэх ганц найдвар нь өнөөдөр “Оюутолгой” л болоод байна. 2019 онд гадаадын шууд хөрөнгө оруулалт

“ОЮУТОЛГОЙ”-Н ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ЗОГСВОЛ МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСАГ ЗОГСОНО

Хөрөнгө оруулалт гэрлийн хурдаар буурахад Засгийн газар голлох үүрэг гүйцэтгэжээ

2019 ОНД ГАДААДЫН ШУУД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ДӨНГӨЖ НЭГ ТЭРБУМ АМ.ДОЛЛАР ЯЛИМГҮЙ ДАВСАН. ҮҮНИЙ 80 ХУВИЙГ “ОЮУТОЛГОЙ” ДАНГААР БҮРДҮҮЛЖЭЭ.

дөнгөж нэг тэрбум ам.доллар ялимгүй давсан. Эдийн засаг сэргэж байсан 2011, 2012 онтой харьцуулахад энэ нь тав дахин буурсан дүн юм. Үүний 80 хувийг “Оюутолгой” дангаар бүрдүүлжээ.

Өөрсдөө үйлдвэрлэгч бус хэрэглэгч орон байж хөрөнгө оруулалтыг үргээх тусгай “ажиллагаа”-г төр засаг нь

энэ дөрвөн жилийн хугацаанд сурамгай хэрэгжүүлжээ. Үр дүнд нь гадаадын шууд хөрөнгө оруулалт сэргэсэнгүй, улам уруудав. “Оюутолгой”-н хөрөнгө оруулалт 1.2 тэрбум байснаа 970 сая ам.доллар болгон танасан. Өөрөөр хэлбэл, гадаадын шууд хөрөнгө оруулалт энэ онд



\$22.4

тэрбум

Монгол Улс олон улсад нээлттэй болж, эдийн засгийн чөлөөт нийгэмд шилжсэнээс хойших 28 жилийн хугацаанд дэлхийн 118 орноос нийтдээ 22.4 тэрбум ам.долларын гадаадын шууд хөрөнгө оруулалт орж ирсэн байна.

☉

Төв банк валютын нөөцөө шавхаж, дэлхийн эдийн засгаас улсаараа “шанаа” хүртэх нөхцөл ингэж бүрдсэн. Үүнд улстөрчдийн үүрэг, оролцоо хамгийн их байлаа.

тэрбум ам.долларт хүрэхгүй байх эрсдэл үүсжээ. Тус компани хөрөнгө оруулалтын хэмжээгээ 200-300 орчим сая ам.доллараар танахаар байгаа талаар төв банк мэдээлсэн.

Монголоо хорлосон эрх баригчдын сүржин үйлдэл эцсийн дүндээ эдийн засагт өнөөдөр сүйрэл авчраад байна. Тэдний балгаар ам.долларын ханш 2806 төгрөгтэй тэнцэж, импортын бараа, бүтээгдэхүүний үнэ тэр хэрээр нэмэгдлээ. Өрхийн амьжиргаа буурлаа. Ядуурал тэллээ. Ажилгүйдэл нэмэгдэж байна. Хэтийдсэн эх оронч үзэл, агуулга бус хэлбэр хөөсөн шийдвэрүүд эдийн засгийг хангалттай доош нь татлаа. Төлөвлөж байсан мега төслүүд цөм гацлаа.

Ам.доллар авчрах хөрөнгө оруулалт ганцхан “Оюутолгой” төслийн гүний уурхай л болж байна. Ойрын 3-5 жилийн хугацаанд олон улсын зах зээлээс манай улс хямд эх үүсвэртэй хөрөнгө оруулалт татах боломж үндсэндээ бүрэн хаагдлаа. Тухайлбал, хөрөнгө оруулагчдын чухалчлан хардаг зээлжих зэрэглэл урагшлах бус ухарч, Саарал болон Хар жагсаалт дотор улсаараа эрэмбэлэгдлээ. Ийм байхад хэн биднийг тоох билээ.

Ирэх оноос төлөх гадаад өр, авлигын индекс, бизнесийн орчны тогтворгүй байдал

хөрөнгө оруулагчдыг цааш нь улам түлхсээр. Энэ байдал хэдий болтол үргэлжлэх эсэх нь тодорхойгүй байна. 2020 он гарснаас хойш хөрөнгө оруулалт тасралтгүй буурсаар. “Оюутолгой” төслийг эс тооцвол гаднын капитал Монголд орж ирэхээс хэдийн татгалзаж эхэлжээ. Өнөөдрийн улстөрчдийн байгаа байдал

ч у х а м д а а шинэ хөрөнгө оруулагчдад итгэл төрүүлэхгүй байна. Монгол уул уурхайн баялагтай боловч засаглал нь баларсан орны тоонд толгой цохидог. Хамгийн сүүлд л гэхэд Европын холбооны хар жагсаалт руу унах болсон нь ердөө л мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэж чаддаггүй, шүүх засаглал нь

булингартсан гэх үндэслэлээр дэлхийн доог тохуу боллоо. Хөрөнгө оруулагчдыг эрх мэдэл бүхий улстөрчид, хууль шүүхийн байгууллага нь заналхийлж, сүрдүүлж, дарамталсаар хамаг хөрөнгийг нь өөрийн болгосон чих сортойх түүхүүд ч бий. Энэ болгон Монголыг сонирхож байсан, бидэнтэй хамтрах бизнесийн түнш, хөрөнгө оруулагчдыг нуруугаа харуулахад хүргэсээр байна. ■

ЭРЧИМ ХҮЧ

ХБНГУ нүүрсний шинэ цахилгаан станцтай боллоо

М.Золбоо, Шинжээч

ХБНГУ 2038 он гэхэд нүүрсний хэрэглээг тэглэх зорилттой байгаа ч энэ долоо хоногт нүүрсний цахилгаан станц шинээр ашиглалтад оруулах гэж байна. Dat-teln-4 нэртэй цахилгаан станцын бүтээн байгуулалтад 1.3 тэрбум ам.доллар зарцуулсан бөгөөд төлөвлөсөн хугацаанаасаа есөн жилийн дараа дуусаж байгаа аж. Шинэ станцтай холбоотой яриа Германд нэлээд маргаан

дагуулж, байгаль орчныг хамгаалагчдын зүгээс хүчтэй шүүмжлэлтэй тулгарч байна. Тэд станцын үйл ажиллагааг эхлүүлэхгүй байхыг Засгийн газраасаа шаардаж байгаа юм. Харин оператор Uniper компани шинэ цахилгаан станцыг 2038 он хүртэл л ашиглана гэж мэдэгджээ. Европын тэргүүлэх эдийн засаг болох Герман улс цахилгаан эрчим хүчнийхээ бараг талыг нүүрсний цахилгаан станцуудад үйлдвэрлэдэг хэвээр байна. ■



ХӨРШ

БНХАУ-ыг чиглэсэн хөнгөн цагааны нийлүүлэлт сэргэж байна









БНХАУ-ын үйлдвэрүүд эргэн нээгдэж байгаатай холбоотойгоор хөнгөн цагааны арилжаа сэргэж байна. Цар тахлын оргил үед хөнгөн цагааны нийлүүлэлтийн илүүдэл үүсээд байсан юм. Харин сүүлийн үед БНХАУ-д хийж буй хөнгөн цагааны нийлүүлэлт ашигтай байхуйц түвшинд хүрчээ. Үүний зэрэгцээ суурь металлуудын үнэ буурч, алтны үнийн хувьд алдагдал нь буурч байна. Металлууд дундаас цайрын үнэ илүү ихээр буураад байгаа

юм. Шалтгаан нь БНХАУ, АНУ-ын харилцаа хурцдаж, эдийн засгийн эрсдэл нэмэгдэж байгаатай холбоотой аж. БНХАУ-ын төсвийн алдагдал өмнөх онд ДНБ-ий 2.8 хувь байсан бол энэ онд нэмэгдэж, 3.6 хувьд хүрэхээр байна. Эдийн засгийг дэмжих багц арга хэмжээний хүрээнд аж ахуйн нэгжүүдэд татварын хөнгөлөлт үзүүлэхээр болов. Мөнгөний зөөлөн бодлогоо үргэлжлүүлж, жижиглэн худалдааны салбарын өсөлтийг нэмэгдүүлэхэд тус улс анхаарч байна. ■

ДОТООДЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ГОЛЛОХ ИНДЕКСҮҮД



ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ГОЛЛОХ ИНДЕКСҮҮД



\$4.5

тэрбум

2011 онд Монгол Улсын түүхэнд хамгийн том хэмжээний буюу 4.5 тэрбум ам.долларын гадаадын шууд хөрөнгө оруулалт бүртгэгдэж байв.

₮2806

Төгрөгтэй харьцах ам.долларын ханш төв банкны зарласан албан ханшаар 2806 төгрөгтэй тэнцэж, түүхэнд байгаагүй дээд хэмжээнд хүрэв.

Т.Элиса, Б.Дашням, Шинжээч

Засгийн газраас өндөржүүлсэн бэлэн байдлыг дахин нэг сараар сунгах шийдвэр гаргасантай холбоотой эдийн засагчдын байр суурийг хүргэж байна. Энэ удаад Монголын банкуудын холбооны Хөрөнгийн удирдлагын мэргэжлийн зөвлөлийн дарга Г.Батжаргалтай ярилцлаа. Тэрбээр эрүүл мэндийн асуудал чухал ч эдийн засгийн хүндрэлийг саармагжуулахын тулд тооцоо судалгаанд үндэслэсэн арга хэмжээ хэрэгжүүлэх нь чухал гэдгийг онцоллоо.



Гэрэл зургийг С.Батсайхан

Эрүүл мэндийг хамгаалахын зэрэгцээ эдийн засагтаа анхаарах шаардлагатай



-Эдийн засгийн хүндрэлүүд банкны үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлж байна вэ?

-Банкны үйл ажиллагаанд хэд хэдэн хүндрэл үүсгэж байна. Тэтгэврийн зээл тэглэсэнтэй холбоотой банкууд ачаалалтай ажиллах болсон. Мөн зээлийн төлөлт хойшлуулсан тул банк руу орох мөнгөн урсгал саарах дүр зураг ажиглагдаж байна. Нийт дүнгээрээ мөнгөний нийлүүлэлт нэмэгдсэн боловч төгрөгийн нийлүүлэлт буурч, гадаад валютын хадгаламж өссөн.


-Та иргэд, аж ахуйн нэгжийн данс хооронд ам.долларын гүйлгээ хийхгүй болсон талаар жиргэсэн байсан. Энэ юу гэсэн үг вэ?

-Валютын зохицуулалтын тухай хуульд Монгол Улсын нутаг дэвсгэрт үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйлгээ хийнэ гэж заасан. Харин Цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засгийн сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуульд үүнийг нарийвчлан зааж өгсөн. Энгийн үгээр тайлбарлах юм бол иргэд хоорондоо валютаар гүйлгээ хийхгүй, хэрэв хийх бол төгрөгт хөрвүүлэн гүйцэтгэх боломжтой. Харин аж ахуйн нэгжүүд дансаараа гүйлгээг чөлөөтэй хийж болно. Ам.долларын зээлтэй бол түүнийгээ төлнө. Мөн гадаад худалдааны компаниуд төлбөр тооцоогоо чөлөөтэй хийж болдог хэвээрээ байгаа.

Банкууд үүнийг харилцан адилгүй хэрэгжүүлж байна. Ойрын хугацаанд Монголын

Эдийн засаг өсөлттэй байх үед төрөлжүүлж, солонгоруулах хэрэгтэй

Эдийн засгийн уналт (1 улиралд)



банкуудын холбоо үүнийг авч хэлэлцээд, Монголбанкнаас хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой ирүүлсэн чиглэлийг нэвтрүүлнэ. Хуулийн хэрэгжилтийн хугацааг 12 дугаар сарын 31 хүртэл гэж заасан тул энэ хүртэл дээрх зохицуулалтаар явна.

-Ам.долларын хадгаламж өссөнтэй уялдан төгрөгийн ханшид ямар нэг нөлөө үзүүлэх үү?

-Сүүлийн 2-3 жил ам.долларын ханш тасралтгүй өслөө. Нэгдүгээр сарын 27-ноос хойш авч хэрэгжүүлсэн хилийн хориг, нүүрсний экспорт тасарсан зэргээс үүдэж, ДНБ 10.7 хувиар уналаа. Үүнтэй холбоотой манай улс руу орох валютын урсгал багасах хандлагатай байна. Төгрөгийн ханшийг хоёр янзаар авч үзэх хэрэгтэй. Нэг нь дотоодын хэрэглээ, инфляцтай холбоотой. Энэ нь гадаад худалдан авалтад ханшаараа

холбогддог. Үүнийг авч үзэхэд ханш айхтар унасан дүр зураг харагдахгүй байна. Сүүлийн зургаан сарын байдлаар инфляц 0.6 хувиар унах шинжтэй байна.

-Засгийн газраас өндөржүүлсэн байдлыг нэг сараар сунгалаа. Энэ нь эдийн засагт хэр дарамт болох вэ?

-Эдийн засагт сөрөг үр дагавартайг эхний улирлын тоон мэдээ харууллаа шүү дээ.

СҮҮЛИЙН 2-3 ЖИЛ АМ.ДОЛЛАРЫН ХАНШ ТАСРАЛТГҮЙ ӨСЛӨӨ. НЭГДҮГЭЭР САРЫН 27-НООС ХОЙШ АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН ХИЛИЙН ХОРИГ, НҮҮРСНИЙ ЭКСПОРТ ТАСАРСАН ЗЭРГЭЭС ҮҮДЭЖ ДНБ 10.7 ХУВИАР УНАЛАА. ҮҮНТЭЙ ХОЛБООТой МАНай УЛС РУУ ОРОХ ВАЛЮТЫН УРСГАЛ БАГАСАХ ХАНДЛАГАТАЙ БАЙНА.

Дэлхийн улс орнууд эдийн засаг тал руугаа нэлээд анхаарал хандуулж байна. Харин манайд эрүүл мэндийн асуудалд илүү анхаарал тавьж байна. Тэгэхээр сайн судалгаа хийж, энэ хоёрыг хослуулах замаар эдийн засгаа дэмжих арга хэмжээ хэрэгжүүлэх нь чухал байна. Манай аж үйлдвэр 24 хувиар, уул уурхайн салбар 33 хувиар уналаа. Хоёрдугаар улиралд энэ нь төдийлэн сэргэхгүй байх. Засгийн газраас яаралтай арга хэмжээ авч, эдийн засгийн бодит дэмжлэгүүдээ шингээх нь зүйтэй юм болов уу.

-Таны хэлсэнчлэн нэмэлт зохицуулалт хэрэгтэй байна. Гэхдээ үүнд шаардлагатай судалгаа, мэдээллийг бид гаргаж чадаж байна уу?

-Судалгаанаас харахад үйлчилгээний салбарууд 50-иас дээш хувийн уналттай байна. Мөн аялал жуулчлалын салбар үндсэндээ зогслоо. Тэгэхээр үүнийг дагаж гарах сөрөг үр дагавар болох ажлын байр алдахаас сэргийлэхийн тулд бодлого чиглэлээ хандуулах нь чухал.

-Өнгөрсөн хугацаанд эдийн засаг өсөх үед иргэдийн амьдралд төдийлэн мэдрэгдэхгүй байна гэж шүүмжилдэг байсан. Харин 10 гаруй хувиар агшсан нь иргэдэд хэр хүчтэй нөлөө үзүүлэх вэ?

-Энэ бол эдийн засгийн бодлогын тэгш хүртээмжтэй байх асуудал л даа. Эдийн засаг хэчнээн өссөн ч ажилгүйдэл, ядуурлын түвшин 30 хувиас доош бууж чадахгүй, тогтмол гуч гаруй хувьтай яваад байгааг байнга ярьдаг. Эдийн засгийн хүндрэл иргэдийн нуруун дээр шууд хүнд тусаж байна. Мөн МҮХАҮТ-ын гаргасан судалгаанаас бизнес эрхлэгчдийн 70 гаруй хувьд хүндрэл учирч байгааг харж болно. Эдийн засаг өсөлттэй байх үед төрөлжүүлж, солонгоруулах, экспортыг нэмэгдүүлж, валютын урсгалыг тогтмол оруулж ирдэг салбаруудыг хөгжүүлэх зэргийг эдийн засагчид байнга ярьсаар ирсэн. Үүнийг шийдвэрлээгүй тохиолдолд нөхцөл байдал хэвээрээ л байх болно. ■



Boeing компани 737 MAX загварын онгоцны үйлдвэрлэлээ сэргээв

Агаарын тээврийн тэргүүлэгч Boeing компани 737 MAX загварын онгоцны үйлдвэрлэлээ дөрвөн сарын дараа сэргээлээ. Энэ загварын хоёр ч онгоц осолдсоны дараа тус компанийн борлуулалт багасаж, нэр хүнд нь буурсан юм. Тус компани 737 MAX-ийн чанар болон угсрах процессыг сайжруулахад анхаарч байгаа

тул үйлдвэрлэлийн гарцыг доогуур түвшинд барих юм байна. Цар тахал аялал жуулчлалын салбарт хүчтэй нөлөөлөөд байгаа энэ үед тус компани ажлын байраа 12 мянгаар цөөлж байгаагаа мэдэгдлээ. АНУ-ын хамгийн том үйлдвэрлэгчдийн нэг Boeing компани энэ долоо хоногт АНУ-д 6770 ажлын байр цомхотгож байгаа ажээ.



☹ Загас агнуурын хөлгүүдийг дагалдах эргийн харуулын онгоцоо байлдааны хөлөг мэтээр тоногложээ.

✍ Филип Хэйжманс

Хятад, АНУ хоёр коронавирусыг эхлээд Хонконгийн өөртөө засах эрхийн асуудлаар маргалдаж буй үед хоёр их гүрэн биетээр тулгарах эрсдэл нэмэгдэж байна. Тэдний цэргийн хөлөг болон байлдааны онгоцууд бие биедээ байнга ойртдог газар Өмнөд Хятадын тэнгисээс өөр байхгүй. Зэвсэгт мөргөлдөөн хоёр талыг сүйрэлд хүргэх нь мэдээж. Аль ч тал нь үүнийг хүсэж буй шинж тэмдэг харагдахгүй байгаа. Гэвч хурцадмал байдлын үед буруу тооцоолол хүсээгүй үр дагаварт хүргэх магадлал бий.

Оны эхний дөрвөн сард Америкийн тэнгисийн хүчин Өмнөд Хятадын тэнгист дөрвөн удаа тандалтын аялал хийсэн. Энэ явдал Хятад, Филиппин, Вьетнам, Малайзын талаас санаархалтай тулгардаг. Үүний зэрэгцээ Хятад улс коронавирусийн хорионоос гарахын хамт тэнгисийн хүчин нь уг бүс нутагт цэргийн сургуулилтаа сэргээжээ. **Халз тулгарахаас сүүлийн мөчид зайлсхийж байсан олон удаагийн түүхтэй хоёр улсын цэргийнхний хувьд энэ нь өндөр бооцоотой муур, хулганын тоглоом юм.** Ерөнхийлөгч Трампын сонгуулийн хугацаа ойртсон хийгээд Ерөнхийлөгч Ши үндсэрхэг үзлийг дэвэргэж буй цаг үед тэнгис дэх сэргөлдөөнийг намжаах болгоомжтой дипломат арга зам олохгүй байна.

Ноён Ши Бүх Хятадын ардын төлөөлөгчдийн их хуралд хэлсэн үгэндээ цэргийнхнийг дайны бэлтгэлээ базаахыг дахин уриалсан. Сингапурт байрладаг Олон улсын судалгааны сургуулийн судлаач Коллин Лин “АНУ, Хятадын хооронд урьдаас төлөвлөсөн зэвсэгт мөргөлдөөн



гарах бараг боломжгүй авч тэдний цэргийнхэн тэнгисийн нэг бүсэд байнга, эрчимтэй үйл ажиллагаа явуулж байна. Ийм дайсагнасан харилцан үйлдэл буруу тооцох буюу бодоход хүргэж, улмаар тохиолдлын буюу санаандгүй хүч хэрэглэх байдал үүсэж болзошгүй. Ингэх нь гал ноцоож, мөргөлдөөнийг хурцатгах аюултай. Энэ бол тооцохгүй байж үл болох эрсдэл” хэмээн үнэлжээ.

“ХАРАМСАЛТАЙ НЬ ТЭДНИЙГ ТОГТООН БАРИХ ХҮЧИН БАЙХГҮЙ. ЗҮҮН ӨМНӨД АЗИЙН УЛСУУД ТЭДЭНТЭЙ ХАРЬЦУУЛАХАД ДЭНДҮҮ ЖИЖИГ” ГЭСЭН ЮМ.

Хятад болон АНУ Өмнөд Хятадын тэнгист олон жил бие биеэ тойрон бүжиглэж байгаа. АНУ энд газар нутгийн санаархалгүй боловч энэ бүсэд дэлхийн худалдааны хөлгүүдийн чухал зам оршдог. Мөн загасаар баялгаас гадна эрчим хүчний батлагдаагүй арвин нөөцтэй гэж үздэг. АНУ бүс нутгийн газар нутгийн маргаанд Хятадын

цэргийн оролцооны эсрэг жижиг улсуудыг дэмжиж байгаа. Бээжин энэ хавьд нисэх зурвас байгуулж, хадан арлууд дээр стратегийн төхөөрөмж суурилуулсан. Түүнчлэн загас агнуурын хөлгүүдийг дагалдах эргийн харуулын онгоцоо байлдааны хөлөг мэтээр тоногложээ.

Сингапурын Үндэсний их сургуулийн Зүүн Азийн хүрээлэнгийн захирал Жен Ёнгниан “Би өнөөгийн байдалд сэтгэл зовниж байна. Хятад, АНУ-ын харилцаа чөлөөт уналтад орсон өнөө үед хоёр талын хатуу бодлоготнууд байдлыг бүр дэвэргэж байна. **Хоёр гүрний хооронд шинэ хүйтэн дайн хурцдаж байгаа нь эргэлзээгүй.** Гэвч хүмүүс бүс нутгийн халуун дайн дэгдэхээс болгоомжилж байна” хэмээн анхаарууллаа. Тэрбээр цааш нь “Харамсалтай нь тэднийг тогтоон барих хүчин байхгүй. Зүүн Өмнөд Азийн улсууд тэдэнтэй харьцуулахад дэндүү жижиг” гэсэн юм.

Хятадын тал Өмнөд Хятадын тэнгист загасчлалын хорио хэрэгжүүлнэ гэж мэдэгдсэн боловч Вьетнам үүнийг ганц талын шийдвэр хэмээн эсэргүүцсэн. Хятадын тал хоёр жижиг арлыг захирахын тулд шинэ дүүрэг байгуулсныг Филиппин улс шүүмжилж байгаа. Тайланд дахь АСЕАН-ы судалгааны төвийн зөвлөгч Пол Чамберз “Зүүн Өмнөд Ази өдөр бүрээр чангарч буй шинэ хүйтэн дайны байдалд шилжиж байна. Энэхүү мөсөн уулын орой нь Өмнөд Хятадын тэнгис юм” гэжээ. ■

Өмнөд Солонгос бодлогын хүүгээ түүхэн доод хэмжээ рүү буулгав

Өмнөд Солонгосын төв банк тус улсын эдийн засаг 1990-ээд он Азийн санхүүгийн хямралаас хойш анх удаа хасах үзүүлттэй гарч болзошгүй гэж таамагласныхаа дараа бодлогын хүүгээ түүхэн доод хэмжээнд хүртэл бууруулахаа

зөвлөл дэмжлэгийн буюу мөнгөний зөөлөн бодлого хэрэгжүүлэхээр шийдвэрлэжээ. Эдийн засгийн өсөлт удааширч, эрэлт буурч буй нь ийм бодлого гаргахад хүргэв. Өмнөд Солонгост коронавирусын тархалтыг хязгаарлах тал дээр дэвшил гарсан ч үе үе дэгдэлт дахиж болзошгүй



зарлалаа. Бодлогын хүүг хагас хувиар буулгаж, 0.5 хувь болгохыг Bloomberg-ийн шинжээчид таамаглаж байсан. Төв банк энэ онд эдийн засаг 0.2 хувиар буурна гэж таамагласан нь хоёрдугаар сарын -2.1 гэсэн таамагтай харьцуулахад гайгүй үзүүлэлт боловч өсөлт рүү энэ ондоо шилжихгүй гэсэн үг юм. Үүний сацуу инфляц удааширч, 0.3 хувьтай байх төлөвтэй байна.

Коронавирусийн тархалтын улмаас төв банкны удирдах

байгаа. Дээр нь олон улсын зах зээл хөл хорионы дараа бүрэн нээгдэж амжаагүй байгаа тул экспортын хэмжээ доошилж байгаа нь ийм таамаг дэвшүүлэх нэг шалтгаан болжээ. Shinyoung Securities сангийн тогтмол орлогын шинжээч Чо Ён-гу “Солонгосын төв банк 0.5 хувийн бодлогын хүүгээ нэг хэсэгтээ барих байх. Гэхдээ энэ ондоо дахиад танах хүлээлт үүссэн” хэмээв. ■

Хятад улс юанийн ханшийг барих хатуу арга хэмжээ авлаа

Хятадын юанийн ам.долларт харьцуулсан ханш



АНУ, Хятадын харилцаа хурацдсаны дараа гадаад зах зээлд эргэлдэж буй юанийн ханш унасан тул Бээжин хүлээлтээс илүү хатуу арга хэмжээ авч, тогтворжуулсан байна. Хятадын Ардын банк нэг ам.доллар 7.1277 юань гэсэн хатуу зарласны дараа Хонконгийн валютын бирж дээр юанийг өчигдөр өглөө 7.1809 ханшаар арилжиж эхлэв. Хэдийгээр энэ нь таамагас үл ялиг дээгүүр ханш боловч арилжаачдад төв банк юанийг хэт унагахгүй гэсэн найдвар төрүүллээ. Харин Хятадын дотоодод юанийн ханш 2008 оноос хойш хамгийн сул түвшинд ирсэн агаад онц өөрчлөгдөөгүй байна.

АНУ-ын Ерөнхийлөгч Дональд Трамп Хятадыг юанийн ханшаар тоглож байна

гэж удаа дараа буруутгасан бөгөөд уг асуудал хоёр талын улс төрийн маргааны нэг сэдэв болсон. 2015 онд юань огцом унах үед дэлхий даяар хөрөнгийн үнэ доошилж, хөрөнгө оруулагчдын зүгээс Хятадын санхүүгийн зах зээлд итгэх итгэл суларсан тул Бээжингийн албаныхан юанийн ханшийг тогтвортой барихаа амласан юм. Сингапур дахь Scotiabank-ны валютын стратегич Гао Чи “Ханшийг зах зээлийг хүлээлтээс арай дээгүүр тогтоолоо. Үүнээс харахад бодлого боловсруулагчид аажим уналтыг ноцтой зүйл биш гэж үзэж байгаа бололтой. Гэхдээ Трамп өмнөхөөс хатуу хориг арга хэмжээ зарлавал юанийн ханш 7.2-ын босгыг давах байх” гэжээ. ■

Уран зурагтай нөхөрлөж, алжаалаа тайлаарай



Ялангуяа абстракт зураг зурахад хүүхэд болоод том хүний дотоод бухимдал гадагшилж, өөрийгөө таньдаг аж

✍ Б.Гандолгор, ЗГМ сонин

Сүүлийн үед хүмүүс зураг зурж алжаалаа тайлах сонирхолтой болжээ. Ялангуяа, нэг төрлийн бясалгал юм. Удаан хугацаанд анхаарлаа төвлөрүүлж, чилтлээ суудаг ч дотоод сэтгэл нь энэ хугацаанд ариусах, шинэ эрч хүчээр сэлбэгдэж байдаг аж. Уран зураг дотроо байгалийн сэдэвт зураг хүнийг илүү тайвшруулж, эрч хүчтэй болгодгийг урлаг судлаачид тэмдэглэжээ.

Цэлэлзэх гүн цэнхэр нуур, түүн дотор хөвж яваа хоёр хун, эсвэл өтгөн шигүү ойн гүнд зугаалж яваа байдлаар зурах нь бясалгалаар хичээллэсэнтэй адилаар төвлөрлийг сайжруулж өгдөг. Нэн ялангуяа хүүхдүүд бусдад сэтгэлээ уудалж, тулгамдсан асуудлаа ярьж чаддаггүй учир ийм байдлаар

стрессээ тайлах хэрэгтэй аж.

Олон улсын судлаачид хүмүүсээс “Хүн илүү нүдтэй бол тэр нь хаана байгаасай гэж хүсэж байна” гэж асуужээ. Насанд хүрэгчдийн дийлэнх нь дагзандаа гэж хариулсан бол хүүхдүүд хуруун дээрээ нүдтэй болохыг хүссэн байна. Хүүхдээрээ зураг зуруулж стрессээс ангижруулахын зэрэгцээ бүтээлч сэтгэлгээг нь хөгжүүлэх хэрэгтэй. Будгийн харандаа, зургийн дэвтэр өгөхдөө тэдэнд дүрэмгүй зурах боломжийг олго. Өөрөөр хэлбэл, тухайн дүрснийхээ өнгийг өөрийнхөө хүссэнээр илэрхийлэх сонголтыг өгөх нь чөлөөт сэтгэлгээг нь хөгжүүлэхэд тус дөхөм болно.

Барууны сэтгэл судлаачид хүүхдийг төрсөн цагаас нь хувь хүн, өөрийн гэсэн үнэ цэнтэй гэж үздэг. Сүүлийн үед олон улсад уран зургаар хүүхэд төдийгүй, том хүнийг эмчлэх сэтгэл зүйн эмчилгээ дэлгэрч байна.

УРАН ЗУРАГ ДОТРОО БАЙГАЛИЙН СЭДЭВТ ЗУРАГ ХҮНИЙГ ИЛҮҮ ТАЙВШРУУЛЖ, ЭРЧ ХҮЧТЭЙ БОЛГОДГИЙГ УРЛАГ СУДЛААЧИД ТЭМДЭГЛЭЖЭЭ. ЦЭЛЭЛЗЭХ ГҮН ЦЭНХЭР НУУР, ТҮҮН ДОТРОО ХӨВЖ ЯВАА ХОЁР ХУН, ЭСВЭЛ ӨТГӨН ШИГҮҮ ОЙН ГҮНД ЗУГААЛЖ БУЙ БАЙДЛААР УРАН ЗУРАГ ЗУРАХ НЬ БЯСАЛГАЛААР ХИЧЭЭЛЛЭСЭНТЭЙ АДИЛААР ТӨВЛӨРЛИЙГ САЙЖРУУЛЖ ӨГДӨГ.

Ялангуяа абстракт зураг зурахад хүүхэд болоод том хүний дотоод бухимдал гадагшилж, өөрийгөө таньдаг аж.

Мөн тухайн хүний зурсан зургаар нь оношлох клиник сэтгэл зүйн арга дэлхий дахинд дэлгэрч байна. Иймээс хэт их ачаалалтай ажилладаг бол амрах агшнаа ашиглаж уран зураг зурж тайвшрах хэрэгтэй. Харин зурсан зургаа сэтгэлзүйч эмчид үзүүлж, өөрийнхөө талаар илүү их мэдээлэл олж авах боломжтой.

Оюуны ачаалалтай ажилладаг хүмүүс болон байнга цус хардаг мэс заслын эмч нарыг уран зурагтай нөхөрлөхийг сэтгэлзүйчид зөвлөдөг. Хүнд өдрийг өнгөрөөсний дараа уран бийрийн ачаар ядаргаанаас ангижирна. Байгалийн сайхныг бийрээр цаасан дээр буулгахдаа намуухан сонгодог ая сонсохоо мартуузай. Хөгжим, уран зургийн энэхүү хослол таныг эрч хүчээр сэлбэх болно. ■

МЭДЭХЭД ИЛҮҮДЭХГҮЙ

Зураг хүсэлдээ хөтлөгдсөн хүмүүст зориулсан сургалтын газрууд цөөнгүй байдаг. Ингээд уран зургийн сургалтын газруудын мэдээллийг хүргэе.

“ХҮСЭЛ” УРАН ЗУРГИЙН СУРГАЛТ

Хүүхэд болон насанд хүрэгчдэд уран зургийн хичээл зааж, авьяас чадварыг нь нээж өгнө.

Тус дугуйлан 2013 оноос эхлэн үйл ажиллагаа явуулж байна. Энэ хооронд хүүхдүүдийн зургийн үзэсгэлэнг зургаан удаа зохион байгуулжээ. Насны хязгааргүй.

Утас: 99033277, 99292941

УРАН ЗУРГИЙН СУРГАЛТ

Монголын уран зургийн галерейн Урлагийн боловсролын төв уран зургийн сургалт явуулж байна.

Утас: 99935394, 327177

УРАН ЗУРГИЙН ДУГУЙЛАН

Decorative Art уран зургийн дугуйлан 8-12 насны хүүхдүүдийн элсэлт авч байна. Мөн насанд хүрэгчдэд зориулсан сургалт явуулдаг.

Хаяг: Бөхийн өргөөний баруун урд талд “ЭРХЭТ” оффис
Утас: 88892548

CANDOR ART HOUSE УРАН ЗУРГИЙН СУРГАЛТ

Таваас дээш насны бүх хүнд нээлттэй
Утас: 99222338


MONET ART STUDIO УРАН ЗУРГИЙН ДУГУЙЛАН

Утас: 88002598

“МЭДРЭМЖ” ЗУРГИЙН ДУГУЙЛАН

Танин мэдэхүй болон сэтгэхүй хөгжүүлэх сургалттай уран зургийн дугуйлан. 3-6, 7-12, 13-17, 18-аас дээш насны ангиллаар сургалтаа явуулдаг.

Утас: 90101518, 70101525



МЭДЭЭЛЭЛ ХУДАЛДАЖ АВНА

ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ СОНИН НЬ НИЙТИЙН ЭРХ АШГИЙГ ХӨНДСӨН,
ТАТВАР ТӨЛӨГЧДИЙН МӨНГӨӨР ТУЙЛЖ БУЙ БАЙДАЛ,
ХУУЛЬ БУС ҮЙЛДЛҮҮДИЙН ТАЛААР БАРИМТТАЙ, ҮНЭН БОДИТ МЭДЭЭЛЛИЙГ
ИРГЭДЭЭС **НЭГ САЯ ХҮРТЭЛ ТӨГРӨГӨӨР** ХУДАЛДАЖ АВНА.

ТАТВАР ТӨЛӨГЧ ИРГЭН ТА ХУУЛЬ БУС ҮЙЛДЛИЙН ХОХИРОГЧ БОЛСОН,
ЭРХ АШГАА ХӨНДҮҮЛСЭН БОЛ БАРИМТАА

FACT@ZGM.MN И-МЭЙЛ ХАЯГААР БОЛОН FACEBOOK-ИЙН
“ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ СОНИН” ПЭЙЖ ХУУДАСТ ИЛГЭЭНЭ ҮҮ

СОНИНЫ РЕДАКЦ

Нэг альянст багтаж буй компаниуд нөгөөдөө саад болохгүйн тулд зах зээлээ гурван хэсэгт хуваахаар шийдлээ

О. Мишээл, ЗГМ сонин

Экс захирал Карлос Гоныг баривчилснаас хойш хүнд нөхцөлд оршин тогтнож буй Renault-Nissan-Mitsubishi альянс коронавирусийн цар тахлаас үүдэлтэй бэрхшээлээ шийдвэрлэхээр чармайж байна. Засгийн газраасаа олон тэрбум еврогийн тусламж авахгүйгээр Renault компани хямралыг давж чадах эсэх нь эргэлзээтэй болсныг Францын Сангийн сайд саяхан мэдэгдсэн. Францын тус үйлдвэрлэгч зардлаа хэмнэхийн тулд зарим загварынхаа үйлдвэрлэлийг бүр мөсөн зогсоогоод байна.

Цаашдид тус альянсын гишүүд бизнес стратегийн шинэ төлөвлөгөөний дагуу, дэлхийн зах зээлийг хувааж ажиллахаар болсон төдийгүй тухайн үед Карлосын идэвхтэй дэмжиж байсан. Францын концерныг Японы үйлдвэрлэгчтэй нэгтгэх төлөвлөгөөг альянс бүр мөсөн орхилоо.

Альянсын гишүүн тус бүр өрсөлдөх чадвар илүү сайн зах зээлдээ тэргүүлж, бусад нь дагалдах “манлайлагч, дагалдагч” зарчим хэрэгжих аж. Шинэ төлөвлөгөөний дагуу Nissan концерн БНХАУ, Умард Америк, Японд манлайлж ажиллах юм байна. Renault цаашид Европ тив, ОХУ, Өмнөд Америк, Умард Африкт төвлөрч, Mitsubishi Зүүн өмнөд Ази - АСЕАН, далайн орнуудын зах зээлд голлох гэж байна.

Дэлхийн бүс нутгийн зах зээл болгонд альянсын гишүүдийн борлуулалт сайтай тодорхой загвар бий. Цаашид бүгд зөвхөн гүйлгээтэй загвартаа төвлөрч, бусад нь гүйлгээтэй загварыг гүйцэж түрүүлэхийн төлөө бүтээгдэхүүнээ хөгжүүлэх аж. “Манлайлагч, дагалдагч” зарчим нь шинэ загвар бүтээж хөгжүүлэх зардлаа 40 хувиар бууруулах боломжтой хэмээн альянсын удирдлага үзэж байна. Уг зарчмыг мөрдсөнөөр ердөө 2025 он гэхэд альянсын үйлдвэрлэж буй нийт загварын тал орчим хувь нь “нийтлэг платформ”-д шилжих учиртай.

Хоёрдугаарт, шинэ бизнес загвар нь альянсын гишүүн үйлдвэрлэгч болгоны технологи хөгжүүлэх ажил үүргийн хуваарийг тодорхойлж өгнө. Nissan автомат жолоодлого, цахилгаан хөдөлгүүрт

RENAULT NISSAN



Renault, Nissan, Mitsubishi дэлхийг хуваахаар төлөвлөлөө

машины хүч дамжуулах анги, БНХАУ-д борлуулах загварын интернэт холболтын системийг хариуцна. Бусад улсын зах зээлд нийлүүлэх ижил төстэй системийг Renault концерн

Android үйлдлийн системд тулгуурлан хөгжүүлэх үүрэг хүлээлээ. Францын концерн мөн автомашины цахилгаан болон цахим систем бүтээхэд голлох ёстой болж байна.

Харин Mitsubishi C, D ангиллын автомашины зах зээлд гибрид хөдөлгүүр хөгжүүлэхэд хүчин чадлаа төвлөрүүлэх юм. ■

Ford-ын машин коронавирус устгадаг боллоо

АНУ-ын Ford компаниас цагдаагийн албанд нийлүүлдэг амдан зогсоогчийн үүрэгтэй Explorer машинуудын программ хангамжийг шинэчлээд, COVID-19-ийн вирусийг устгах боломж бүрдсэнийг Fox News мэдээллээ.

Шинэчилсэн программ хангамжтай цагдаагийн машины климат-контроль систем бүхээг дэх агаарын хэмийг 15 минутын турш цельсийн 45 градуст халаах замаар ариутгадаг байна. Охайогийн их сургуулийн судлаачдын хийсэн туршилтаас үзвэл автомашины бүхээгт 15 минутын турш халуун агаар үлээлгэхэд агаар дахь

АВТОМАШИНЫ БҮХЭЭГТ 15 МИНУТЫН ТУРШ ХАЛУУН АГААР ҮЛЭЭЛГЭХЭД АГААР ДАХЬ КОРОНАВИРУСЫГ ОРОЛЦУУЛААД БҮХ ТӨРЛИЙН ВИРУС, БАКТЕРИ 99 ХУВЬ УСТАЖ БАЙГАА ЮМ.

коронавирусийг болон бүх төрлийн вирус, бактерийг 99 хувь устгах

байгаа юм.

Программ хангамжийн шинэчлэл 2013-2019 онд үйлдвэрлэсэн Ford Explorer автомашинд тохирно. Машины үйлдвэрлэсэн оноос шалтгаалаад ариутгах ажиллагааг ухаалаг утасны аппликэйшнээр юм уу жолооны хүрдэн дээрх круиз-контролын товчлуураар код оруулах замаар идэвхжүүлэх боломжтой аж.

Ариутгах ажиллагаа эхэлмэгц бүхээгийн хянах самбарт гэрэл болон дуут сануулга мэдэгдэх бөгөөд ариутгал дуусаж автомашины бүхээгийн температур аюулгүй түвшинд буцмагц мөн сануулга гарах юм. ■



Tesla компани бүх цахилгаан машиныхаа үнийг буулгажээ

АНУ-ын цахилгаан хөдөлгүүрт автомашин үйлдвэрлэгч Tesla компани бараг бүх загварынхаа үнийг бууруулахаар шийдлээ. Цар тахал дэгдсэнтэй уялдан коронавирусийн халдварыг хязгаарлах зорилгоор эрх баригчид хөл хорио тогтоосон нь дэлхийн ихэнх улсын эдийн засагт, ялангуяа автомашин үйлдвэрлэлийн салбарт ноцтой хохирол учруулав.

Эдийн засгийн уналт нүүрлэсэн өнөөгийн нөхцөлд нийцүүлж Илон Маскийн компани


үйлдвэрлэж буй бараг бүх загварынхаа үнийг хямдруулав. Тус үйлдвэрлэгчийн хамгийн гүйлгээ сайтай, хямд төсөр загвар гэж болох Model 3-ын үнэ хүч дамжуулах ангиасаа шалтгаалахгүйгээр 2,000 ам.доллараар буулаа. Европын Холбооны зах зээлд 39,990 ам.доллараар зарагддаг Model 3 Standard Range Plus загварын

үнэ өдгөө 37,990 болов.

Манлай загвар гэгддэг Model S-д бүр ч өгөөмөр хямдрал. Жишээ нь, Model S Long Range Plus загварын үнэ 74,990 ам.доллараас эхэлдэг болсон нь 5,000 ам.доллараар хямдарсан гэсэн үг. Хамгийн үнэтэй хувилбар болох Model S Performance-ын үнэ мөн адил 5,000 ам.доллараар буужээ. Тус компанийн хамгийн үнэтэй нь төдийгүй хамгийн хүчирхэг

цахилгаан машины үнэ өдгөө 94,990 ам.доллар болоод байна.

Model S загварын хоёр хувилбарын үнэ мөн л тус бүр 5,000 ам.доллараар бууж, 80,000-аас үнэ эхэлдэг болов. Шинээр гараад удаагүй, захиалагч ихтэй байгаа загвар болох Model Y-ийн үнийг компани хямдруулалгүй хэвээр нь үлдээжээ. ■



ЗӨВ СОНГОЛТ

ЗӨВ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

110 АЙЛЫН 16 ДАВХАР БАРИЛГА



Park East цогцолбор хотхон нь хотын хамгийн эко бүс болох Богд уулын бэл, хатан Туулын хөвөөнд орших Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгийн үзэсгэлэнт байгаль, эрүүл цэвэр агаарт сүндэрлэн боссон



Жилээс жилд
үнэ цэн нь улам
нэмэгдэх орчин, тав
тух тансаг байдлыг
цогц шийдсэн



БАРИЛГЫН ДАВУУ ТАЛ:

- ◆ Олон улсын барилгын салбарт ихээр ашиглаж буй сүүлийн үеийн aluminum буюу хөнгөн цагаан гадна фасадтай
- ◆ Дэлхийн №1 ХБНГУ-ын Aquatherm фермийн хуванцар шугам хоолойтой
- ◆ Нар үзэх архитектурын зөв төлөвлөлт
- ◆ Айл бүр шалнаасаа тааз хүрсэн дугуй хэлбэрийн урагшаа харсан цэлгэр том цонхтой
- ◆ Цонхны хөшгийг автоматжуулсан тоноглолтой
- ◆ Айл бүрт бүрэн автомат суултуур
- ◆ Төвийн инженерийн шугам сүлжээнд холбогдсон
- ◆ Гэрээсээ шууд Үндэсний цэцэрлэгт хүрээлэн рүү гарч болдог
- ◆ Автомашины аюулгүй хүүхдийн тоглоомын талбай, гүйлтийн замтай
- ◆ Галын аюулгүй байдлын систем
- ◆ 24 цагийн лифт
- ◆ Дулаан болон гадна талбайн том зогсоол
- ◆ 8 баллын газар хөдлөлтөд тэсвэртэй
- ◆ Бүрэн цутгамал хийцтэй



БОРЛУУЛАЛТЫН АЛБА:



99090142, 88114566,
90092678, 99090063

БАЙРШИЛ:

Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгийн чанх ард Дүнжингарав худалдааны төв, ЕБС-ийн 133-р сургууль болон Олон улсын хөтөлбөртэй улсын "Монгол Тэмүүлэл" лаборатори сургуулийн дэргэд

М.Баярбат

ӨӨРИЙНХӨӨ ӨНЦГӨӨР ЕРТӨНЦИЙГ ХАРВАЛ ИЛҮҮ ӨНГӨЛӨГ

✍ Н.Сийлэн, ЗГМ сонин

Энэ удаагийн “Гоо сайхан” буланд фитнес модель М.Баярбатыг онцолж байна. Өөрийгөө гурван үгээр зогсолтгүй, уян хатан, амттай гэж тодорхойлсон тэрбээр суралцахын хажуугаар хувийн бизнесээ эхлүүлж, бодилбилдингийн багшаар ажилладаг хөдөлмөрч нэгэн юм. Түүний сайхан биеийн нууц нь фитнесээр тогтмол хичээллэсний үр дүн аж.

- Биеийн жин: 75 кг
- Биеийн өндөр: 175 см
- Үсний өнгө: Хар
- Нүдний өнгө: Хар бор
- Төгссөн сургууль: ХААИС-д суралцдаг
- Ажил: Бодилбилдингийн багш. Мөн хувиараа бизнес эрхэлдэг
- Мэргэжил: Эдийн засагч
- Идэх дуртай хоол: Шинэ, эрүүл, амттай бол бүх хоол
- Дуртай сүрчиг: Giorgio armani, Dior
- Дуртай өнгө: Хар
- Хобби: Шинэ зүйл оролдох, амжилттай яваа хүний ярилцлага сонсох, намтар унших
- Зорилго: Нууц
- Дуртай брэнд: Nike
- Баримталдаг зарчим: Өөрийнхөө өнцөг, линзээр ертөнцийг харвал илүү өнгөлөг
- Нууц авъяас: Бариа, массаж хийхдээ сайн
- Багын хоч: Алаг нүдэн
- Үзэх дуртай кино: Fight club, Harry Potter, 1917
- Хэлэх дуртай үг: Яагаад би биш гэж, яагаад чи биш гэж
- Өглөөг хэрхэн эхлүүлдэг вэ: Намуухан жазз ая сонсонгоо ус ууж, шүршүүрт ордог
- Утасны дэлгэцэн дээрх зураг: Японы хуучин сүмийн зураг
- Instagram хаяг: bayrtmunkh_volt
- Биеэ хэрхэн хөгжүүлдэг вэ: Тогтмол фитнес явдаг. Сүүлийн үед иог сонирхож байгаа.



MOSEL
—MONGOLIA—

АРЬС АРЧИЛГААНЫ ГҮН
ЦЭВЭРЛЭГЧ ХӨӨСӨН САВНА
ҮНЭ:15000



ӨДӨР ШӨНИЙН ТОС
ҮНЭ:20000



ГҮН ЧИЙГШҮҮЛЭГЧТЭЙ,
ӨӨ ДАРАГЧТАЙ, ӨӨ КРЕМ
ҮНЭ:25000



ХҮРГЭЛТ ҮНЭГҮЙ

☎ 80137000

📌 mosel mongolia

📷 Mosel official

MOSEL MONGOLIA КОМПАНИ
МОНГОЛД ҮЙЛДВЭРЛЭВ

The Voice шоу бол үндэсний урлагаа сурталчлах маш том боломж

Энэ шоу Австрали төдийгүй дэлхий даяар цацагдах учир урилгыг нь дуртайяа хүлээн авсан

Т.Намуунболор, ЗГМ сонин

Хэдхэн хоногийн өмнө Австрали улсын The Voice шоуны тайзнаа морин хуурын аялгуу эгшиглэж, ардын уянгат дуу, дахин давтагдашгүй хөөмийн чимээ Монголын төдийгүй дэлхийн хүн зоньг уяраасан билээ. Энэ аялгууг сонсоод эх нутгаа санасан монголчууд нулимс мэлмэрүүлж, монгол хүн болж төрснөөрөө бахархаж, огшиж байв. Харин энэхүү гайхамшигт аялгууг эгшиглүүлсэн эрхэм авьяастан бол Австрали улсад ажиллаж, амьдардаг монгол залуу Ганбүргэдийн Бөхчулуун билээ.

-Урилга хүлээн авсанд баярлалаа. Хүмүүс таныг "Домог" хамтлагийн гишүүн байсан гэдгээр нь илүү сайн мэддэг. Уншигчдад маань өөрийгөө танилцуулахгүй юу?

-Намайг Г.Бөхчулуун гэдэг. Хөгжим бүжгийн консерваторыг төгссөнөөсөө хойш үндэсний хөгжмөө 22 жил тоглож байна. Харин хөөмийлж эхлээд 15 жил өнгөрчээ.

-Яагаад The Voice шоуны тайзыг зорих болов?

-Үндэсний урлагаа хөгжүүлэх, түгээх, олон улсад сурталчлах нь уран бүтээлч хүн төдийгүй монгол хүн бүрийн эрхэм үүрэг. Би The Voice шоуны тайзыг үндэсний урлагаа сурталчлах маркетингийн маш том боломж гэж харсан. Австрали төдийгүй дэлхий даяар цацагдах учир урилга ирэхэд нь дуртайяа хүлээн авсан. Монгол Улс гэж ямар улс вэ, ямар өв соёлтой вэ, бидний дуу хөгжим хэчнээн гайхалтай вэ гэдгийг харуулахыг хүссэн. Зорилгоо ч бас тодорхой хэмжээнд биелүүлж чадсан болов уу. Би Австралид ирээд 11 жил болж байна. Ихэнх

австраличууд "Монгол гэж ямар улс вэ, Хаана байдаг вэ, Хятадын нэг хэсэг үү" гэх мэт асуулт асуудаг. Энэ хандлагыг ч бас өөрчлөхийг хүсдэг.

-Таны сонгосон шүүгч Гай Себастьян "Бид өөр хэний ч хийж чадахгүй зүйлийг хийдэг гайхалтай гишүүнтэй боллоо" гэж хэлсэн байсан. Яагаад тэр шүүгчийг сонгох болов?

-Миний дуртай дуучин л даа. Намуухан хэмнэлтэй, гоё дуунуудтай. The Voice-ийн урилга ирэхэд нь би ямар хүмүүс шүүх талаар нь ч тодруулж асуусан. Урилгыг нь хүлээн авахад нөлөөлсөн бас нэг хүчин зүйл Тай Сибастян байсан гэж хэлж болно.

-Тайзан дээрх мэдрэмж, үзэгчдийн сэтгэгдэл ямар байсан бэ?

-Үзэгчид маш сайхан хүлээн авч, өндөр сэтгэгдэлтэй байсан. Хамгийн сонин нь тайзан дээр гарах үед надад ямар нэг мэдрэмж төрдөггүй. Бүр сандардаг ч үгүй. Би сандарч, догдлох юмсан гэж хүсдэг шүү. Заримдаа сандарсан үед хүнээс сэтгэл хөдлөл шингэсэн жинхэнэ амьд, мэдрэмжтэй уран бүтээл төрдөг шүү дээ. Албаар сандрах гэж оролддог ч нэг л болж өгдөггүй юм /инээв/. Олон жил ажиллаад ирэхээр дөжирчихдөг байж мэднэ.

-Эхний шатанд дуулсан дуугаа таныг өөрөө зохиосон гэж сонссон. Эх орноо санасан олон хүний зүрх сэтгэлийг дэвтээж байх шиг байна?

-Миний ээж Хөвсгөлийн Хатгалын хүн. Ээжийгээ, Хөвсгөлийнхөө үзэсгэлэнт байгалийг сэтгэлдээ харж, тэр мэдрэмжээ илэрхийлсэн. Нам гүм байдал, байгалийн аниргүй чимээг сэтгэлдээ байнга хардаг. Энэ дууг дуулахаар эх орон, ээж аавыг минь санагдуулж, төрсөн гэртээ очоод ирсэн юм шиг л мэдрэгддэг. Ямар сайндаа



МОНГОЛЧУУД МААНЬ УРМЫН ҮГЭЭР УГТАЖ АВСАН БОЛОХООР ҮНЭХЭЭР САЙХАН БАЙСАН. БИЧЛЭГ ЦАЦАГДСАНЫ ДАРАА МАНАЙХАН ЦАХИМД ДАВАЛГААЛЖ БАЙГААГ ХАРААД НЭГ ИХ ТОМ АРМИД ОРЧИХСОН МЭТ СЭТГЭГДЭЛ ТӨРСӨН. МОНГОЛ УЛС ГЭЖ ЯМАР УЛС ВЭ, ЯМАР ӨВ СОЁЛТОЙ ВЭ, БИДНИЙ ДУУ ХӨГЖИМ ХЭЧНЭЭН ГАЙХАЛТАЙ ВЭ ГЭДГИЙГ ХАРУУЛАХ НЬ ХАМГИЙН ЧУХАЛ.

дуулж байхдаа би шүүгчид эргэсэн эсэхийг ч анзаараагүй байсан.

-Эх орныхоо юуг хамгийн их санадаг вэ?

-Ээж, аавыгаа л хамгийн их санах юм даа. Би Монголдоо зун бүр очдог. Өнгөрсөн жил ч бас очсон. Харамсалтай энэ жил чадахгүй бололтой. Эх орондоо очихоор онгоцноос буугаад л шал өөр болчихдог. Нэг л сайхан тайван, хамаг бие сулраад л.

-Таныг өөрийн гэсэн хамтлагтай гэж дуулсан. Мэргэжлээрээ ажиллаж байгаа юу?

-Тийм ээ, мэргэжлээрээ ажиллаж байна. Би хоёр хамтлагтай. Нэг хамтлагтаа "Ая" гэж нэр өгсөн. Манай хамтлаг саяхан Монголын хамгийн ховор амьтдын нэг мазаалайд зориулсан шинэ ая зохиосон байгаа. Энэ амьтны тухай олон хүн мэдвэл, мөхлөөс аврах боломжтой. Харин нөгөө хамтлагийн маань нэр Equus. Энэ нь латинаар морь гэсэн утгатай. Мөн Австралийн сургуулиудад хөгжмийн хичээл зааж, бага, дунд сургуулиудаар

тоглолт хийдэг. Энэ улсад маш олон үндэстэн, ястан байдаг учир бүх орны хөгжимчдийн уран бүтээлийг толилуулж, хүүхдүүдийнхээ хөгжмийн боловсролд анхаарахаас гадна хөгжмөөр дамжуулан улс үндэстнүүдийн талаарх мэдлэгийн хүрээг нь тэлдэг. Хааяа хоббигоороо уран зураг болон интерьер дизайны чиглэлээр ажиллаж байна.

-Танай хамтлагууд бүтээлээ ямар жанраар туурвидаг вэ?

-Монгол ардын дуу болон уртын дууг орчин үеийн хэмнэлд оруулж тоглодог. Ерөнхийдөө этно гэж хэлж болно.

-Гишүүд нь монгол хүмүүс үү?

-Бүх гишүүд маань Австрали.

-Хамтлаг гэснээс та "Домог" хамтлагаас яагаад гарсан юм бэ?

-2009 онд Австрали руу ирээд, "Домог" хамтлагийнхаа уран бүтээлд оролцох боломжгүй болсон. Бид хөгжим бүжгийн нэг ангийн хүүхдүүд шүү дээ. Байнга холбоотой байдаг. Улс орнууд хилээ хааж, хөл хорио тогтоосон болохоор тоглолтууд

нь цуцлагдаж, манай хэд амралтын байдалтай байгаа.

-Австралид халдварын нөхцөл байдал ямар байна вэ. Уран бүтээлд нь нөлөөлж байна уу?

-Хөл хорио урлагийн салбарынханд хамгийн их нөлөөлж байна. Бүх тоглолтууд цуцлагдсан. Хэзээ хэвийн болох талаар мэдээлэлгүй байна.

-Та хөгжмийн ертөнцтэй хэрхэн холбогдож байв. Удамд нь урлагийн хүмүүс бий юу?

-Өвөө маань хөгжмөө өөрөө урладаг, гарын дүйтэй дархан хүн байсан юм гэнэ лээ. Бас сайхан дуулдаг, хөгжим тоглодог тийм буурай байж. Би өвөөгөө харж байгаагүй ээ. Аав маань өвөөгөөс гарын урыг нь өвлөсөн барилгын инженер мэргэжилтэй, дархан хүн. Харин авга ах маань хөгжим тоглох авьяасыг нь өвлөсөн, МУГЖ н.Идэрбат гэж хүн бий. Энэ авьяас нь надад удамшсан болов уу даа.

-Таныг тайзан дээр байхад эхнэр тань нулимс дуслуулж байсан. Цахим орчинд олон монголчууд талархлаа илэрхийлсэн байсан. Танд ямар сэтгэгдэл төрж байна?

-Монголчууд маань урмын үгээр угтаж авсан болохоор үнэхээр сайхан байсан. Бичлэг цацагдсаны дараа манайхан цахимд давалгаалж байгааг хараад нэг их том армид орчихсон мэт сэтгэгдэл төрсөн. Баярлаад л /инээв/.

-Та TEDxSydney-н тайзан дээр морин хуураа эгшиглүүлж байсан. Энэ дурсамжаасаа хуваалцахгүй юу?


-TEDxSydney-д 2016 онд оролцож, 4500 гаруй хүний өмнө хуур татсан. Морин хуураа тоглохоос гадна тэдгээр үзэгчийг удирдаж, хоор дуулсан учраас үнэхээр үгээр хэлэмгүй, бахархалтай мөч, гайхалтай тайз байсан.

MOTHER AND FATHER ДУУ ЭХ ОРОН, ЭЭЖ ААВЫГ МИНЬ САНАГДУУЛЖ, ТӨРСӨН ГЭРТЭЭ ОЧООД ИРСЭН ЮМ ШИГ Л МЭДРЭГДДЭГ. ТАЙЗАН ДЭЭР БАЙХДАА БИ ШҮҮГЧИД ЭРГЭСЭН ЭСЭХИЙГ Ч АНЗААРААГҮЙ.

-Гаднын иргэд манай үндэсний хөгжим, хөөмий, ардын урлагийн соёлыг хэрхэн хүлээж авдаг вэ?

-Маш их хүндэтгэн хүлээж авдаг. Би хөгжмөөр дамжуулж эх орноо сурталчлах нь хамгийн зөв гэж боддог. Чаддаг юмаа хийгээд, эх орондоо хувь нэмэр оруулах нь монгол хүн бүрийн үүрэг.

-Монголын үндэсний хөгжим сүүлийн жилүүдэд эрчээ авч



Тэрбээр этно урсгалаар тоглодог "Ая" болон Equus гэх хоёр хамтлагтай бөгөөд Австралийн сургуулиудад хөгжмийн хичээл зааж, бүх бага, дунд сургууль тоглолт хийдэг аж.

дэлхийн зах зээлд хүч түрж байна. Энэ амжилтыг та хэрхэн харж байна?

-Маш ухаантай алхам хийх ёстой. Ямар хүмүүстэй хамтран ажиллах, хамтрах гэж буй байгууллагын чадвар, нэр хүнд, гарын үсэг зурах гэж буй гэрээний нөхцөл гээд олон зүйлийг анхаарах шаардлагатай. Тайзан дээр нэгэнт л гарсан бол ур чадвартай нь хүссэн хүсээгүй цаашаа явна. Менежерүүд чамайг авьяастай, амжилтад хүрэх ирээдүйтэй бол шүүрнэ гэсэн зарчимтай.

-Таны уран бүтээлийн онгод юу вэ?

-Тухайн үеийн мэдрэмж, уран сэтгэмжээс шалтгаална. Тархин дотроо зураг зурахтай адил юм уу. Тэр зургийг яаж хөгжмийн хэлээр илэрхийлж, хүмүүст ойлгуулах вэ гэдэгт төвлөрдөг учраас өөрийнхөө гүнээс, дотроосоо тоглох хэрэгтэй.

-Цаашдын зорилгоосоо хуваалцахгүй юу?

-The Voice шоунд орсноор миний нэг зорилго биелсэн гэж хэлж болно. Монгол дуу гэж юу вэ, морин хуур гэж юу вэ, хөдөө

гэж юу вэ гэдгийг олон хүн мэддэг боллоо. The Nu хамтлаг эх орноо сурталчлах үүргийг хамгийн сайн биелүүлж байна. Намайг оюутан байхад жаахан хүүхдүүд Хөгжим бүжгийн коллежид орж ирж байлаа. Дэлхийд нэрээ мандуулж байгаа тэднээр бахархахгүй байхын аргагүй. Мөн Домог, Хөсөгтөн гээд үндэсний өв соёлоо тээж, хөгжүүлж яваа бүх уран бүтээлчдээрээ маш их бахархдаг шүү. Би ч гэсэн хичээнээ гэж хэлмээр байна. Бүх монголчууддаа баярлалаа.■

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

2020.05.29

Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар нь Сонгинохайрхан дүүргийн 28 дугаар хороонд хэрэгжүүлэх Гэр хорооллын дахин төлөвлөлтийн гадна дулаан хангамжийн ажлын зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний худалдан авах ажлыг хэрэгжүүлэх зорилгоор зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах гэж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.

Энэхүү зөвлөх үйлчилгээ НХААГ-20/0130 дугаартай болно. Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх нь уг үйлчилгээг гүйцэтгэх чадвартайг нотлох дараах мэдээллийг ирүүлнэ. Үүнд:

- 3.1** Улсын бүртгэлийн гэрчилгээний эхээс хийсэн өнгөт хуулбар
- 3.2** Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тодорхойлолт Харьга дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсээс нийгмийн даатгалын шимтгэлийн өргүй тухай тодорхойлолт
- 3.3** Захиргааны хэргийн шүүхийн тодорхойлолт /Энэхүү тодорхойлолтод Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.4 дэх заалтын талаар тусгасан байна./
- 3.4** Дээрх тодорхойлолтыг тендер зарлагдсан өдрөөс хойш авсан байх ба тендер нээсэн өдрийн байдлаар хүчин төгөлдөр байна
- 3.5** Хугацаа хэтэрсэн зээл болон зээлийн хүүгийн өргүй тухай харилцагч банкны тодорхойлолтыг улсын бүртгэлийн гэрчилгээнд заасан банк тус бүрээс ирүүлнэ.
- 3.6** Татварын ерөнхий газрын www.e-tax.mt.mn сайтыг ашиглан цахим тодорхойлолтыг ирүүлэх ба ингэхдээ хуудсын доод хэсэгт байрлах тоо, тэмдэгт орсон 36 оронтой нууц дугаарыг гаргацтай байхаар ирүүлнэ. Монгол Улсын, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу татвар хураамж, төлбөрөө төлсөн байна. Тодорхойлолт нь тендер нээсэн өдрийн байдлаар хүчин төгөлдөр байна.
- 3.7** Ижил төстэй ажлыг хамгийн багадаа нэг удаа гүйцэтгэсэн байвал зохих хугацаа: Төсөвт өртгийн 30 хувиас багагүй үнийн дүнтэй ажил гүйцэтгэсэн байна. Сүүлийн 2 жил (2018, 2019 он) гүйцэтгэсэн ажлын гэрээ, акт, захиалагчийн тодорхойлолтыг хавсаргана.
- 3.8** Борлуулалтын хэмжээ: Сүүлчийн 2 жил /2018, 2019 он/-ийн борлуулалтын орлогын дундаж нь төсөвт өртгийн 50%-иас багагүй байна.
- 3.9** Голлох болон инженер техникийн ажилтнуудын дэлгэрэнгүй мэдээллийг ирүүлнэ.
- 3.10** Тусгай зөвшөөрлийн хуулбарыг эхээс баталгаажуулж ирүүлэх

Зураг төсөл боловсруулах байгууллага нь:
Барилга, хот байгуулалтын яам

1.3.1 Дулааны гол шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн

ажлын зураг /түүнээс дээш/

1.2.1 1-10 хүртэл давхар барилга байгууламжийн барилга архитектур, орчны ерөнхий төлөвлөгөө, тохижилт, өндөржилт, барилга бүтээцийн зураг төсөл, барилгын зохион байгуулалтын зураг төсөл (БЗБТ, АГТ, ҮЗБТ) /түүнээс дээш/

1.2.4 Дотор усан хангамж, ариутгах татуурга, халаалт, салхивч агаар сэлгэлт, хөргөлтийн систем, гадна салбар шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн зураг төсөл /түүнээс дээш/

1.2.5 Дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамж, гадна салбар шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн зураг төсөл (10кВ хүртэл) Дотор радио холбоо, галын болон бусад дохиоллын систем, дохиолол мэдээллийн байгууламжийн зураг төсөл, хамгаалалтын систем түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологи, компьютер хангамжийн дотоод сүлжээ, гадна салбар шугам сүлжээний зураг төсөл Орон сууц, олон нийт, үйлдвэрийн барилгын болон тоног төхөөрөмжийн хянах, хэмжих хэрэгсэл /КИП/, автоматикийн зураг төсөл /түүнээс дээш/

Эсхүл

ЗТ-4.5 Дулааны гол (магистраль) шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн ажлын зураг /түүнээс дээш/

ЗТ-2.1 Архитектур, барилга бүтээц, барилгын зохион байгуулалтын зураг төсөл (БЗБТ, АГТ, ҮЗБТ) /түүнээс дээш/

ЗТ-6.1 Барилга байгууламжийн дотор ус хангамж, ариутгах татуургын систем, гадна салбар шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн зураг төсөл /түүнээс дээш/

ЗТ-6.2 Барилга байгууламжийн дотор халаалт, салхивчийн систем, гадна салбар шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн зураг төсөл /түүнээс дээш/

ЗТ-11.1 Барилга байгууламжийн техник, эдийн засгийн үндэслэл, төсөв /түүнээс дээш/

Сонирхсон этгээд нэмэлт мэдээллийг **2020 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн 11:00 цаг** хүртэл авч болох бөгөөд Цахим Худалдан авах систем (www.tender.gov.mn)-ээр мэдүүлгээ **2020 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 11:10** цагийн дотор ирүүлнэ үү.

УЛААНБААТАР ХОТ, ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ, 4 ДҮГЭЭР ХОРОО, БАГА ТОЙРУУ-15, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ЗАХИРГААНЫ IV БАЙР, 10 ДУГААР ДАВХАР, НИЙСЛЭЛИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР, УТАС: 75757807 ЦАХИМ ХАЯГ: WWW.TENDER.GOV.MN, WWW.UB-PROCUREMENT.MN

ZGM DAILY

⊖ ERD: Extracting operation is proceeding normally

In accordance with the company's statement, planned works have been slowed due to uncertainty, however, mining and licensing work have been continuing these days.

⊖ Total COVID-19 cases rise by 13, reaching 161

According to the NCCD, 13 new COVID-19 cases which are all imported from Russia were confirmed as a result of tests taken from 517 citizens on May 27.



Image by Batsaikhan.S

GOLD PURCHASE MAY GROW TO 23 TONS IN 2020

As of today, the Bank of Mongolia (BoM) has purchased 8.5 tons of precious metals

Aminaa.U, ZGM Daily

As of today, the Bank of Mongolia (BoM) has purchased 8.5 tons of precious metals since the beginning of the year. Specifically, gold accounts for 6.8 tons of and silver 1.7 tons. The gold purchase has doubled from the previous year, and the central bank and the government are estimating to increase it to 23 tons this year.

Mongolia's official foreign exchange reserves stood at USD 4.1 billion in the first three months. This is the level that can provide import consumption for nine months. The Monetary Policy Guidelines had included the necessity to increase it to USD six billion.

MONGOLIA'S OFFICIAL FOREIGN EXCHANGE RESERVES STOOD AT USD 4.1 BILLION IN THE FIRST THREE MONTHS.

The main resource for increasing foreign exchange reserves is in the gold sector. In this context, the Parliament has passed a resolution to resolve the issue of providing concessional financing to gold mining companies by the central bank and to implement the Gold 2 program. ■

INDUSTRY

Construction materials import drops amid pandemic

According to the Building Material Manufacturer's Association of Mongolia, the import of construction supplies and some types of construction materials has sharply decreased due to the pandemic.

Several construction materials companies have come to a standstill due to a shortage of foreign workers. However, construction is proceeding normally as domestic construction material producers supply 60 percent of the market.

Specifically, the association reports that it supplies domestically produced construction materials and imported resources. Cement, the main raw material for construction, is temporarily in short supply domestically, according to industry insiders at Barilga Expo. Demand for cement is expected to increase in spring, but

domestic cement producers say they can meet their demand.

Four domestic cement plants are currently operating normally, producing more than 9,000 tons of cement daily. The Ministry of Construction and Urban Development emphasizes that it is sufficient to meet the regular demand for cement.

In 2019, local cement producers

supplied 1.6 million tons of cement to the market, according to the Mongolian Construction Materials Association, which is stagnating due to human resources. This is mainly due to the consultants and employees of these companies depend on foreign workers. In terms of reinforcement, domestic companies cannot fully supply it, and 70 percent of it is imported. ■



ZGM: HIGHLIGHTS


■ POLITICS

The General Election Commission (GEC) registers all 76 candidates of the DP for the upcoming parliamentary elections, as they have not been involved in corruption or official misconduct.

Prime Minister Khurelsukh Ukhnaa visits the construction site of the Chinggis Khaan Museum. In about two months since its construction launch, the foundation of the building has been completed, kicking off the work for the ground floor recently.

■ ECONOMY

Top 20 index drops 0.14 percent, to 15,960.45 points. MSE A index decreases 0.04 percent, to 7,722.5 points. MSE B index increases 0.43 percent, to 7,254.06 points. Market cap stands at MNT 2.41 trillion.



■ SOCIETY

Mongolia ranked second behind Germany in terms of the percentage of its nationals repatriated from abroad compared to the entire population, according to the SEC. A total of 8,498 citizens have returned from 30 countries since the state of readiness was raised.

On May 27, a ceremony to present the certificate of the Traditional technique of making Airag in Khokhuur and its associated customs, which was inscribed on the UNESCO Representative List of Intangible Cultural Heritage of Humanity was organized at the Ministry of Foreign Affairs.

MINING

ERD: Extracting operation is proceeding normally



Bayartsetseg.D, ZGM Daily

Erdene Resource Development (ERD)'s President and CEO Peter Akerley recaps recent accomplishments and lays out the path to first gold at Bayan Khundii Gold Project in an annual letter to shareholders. He emphasized, "Despite the uncertainty in the world today, we have a tremendous opportunity to generate strong returns for our investors and to make a positive impact within our communities and for our regional and national stakeholders in Mongolia. Our management and directors are deeply invested in the company and driven to create shareholder value and to improve livelihoods for all stakeholders."

According to the company's statement, planned works have

been slowed due to uncertainty, however, mining and licensing work have been continuing these days. Additionally, the company continues to make significant progress on Bayan Khundii Gold Project Bankable Feasibility Study (BFS) and Environmental and Social Impact Assessment, results to present mid-2020.

As the preliminary feasibility study shows, it is possible to process ore with an average gold content of 3.7 grams per ton and extract an average of 61,000 ounces of gold annually.

The Altan Nar deposit, part of the Khundii project, is estimated to process 3.46 grams of gold per ton and produce 48,000 ounces of gold per year. ERD's stock closed at USD 0.23 on the Toronto Stock Exchange (TSX) after the report.

SOCIETY

Mongolia may conduct charter flight to Kazakhstan in the first half of July

Bayartsetseg.D, ZGM Daily

On May 27, Deputy Prime Minister Enkh-tuvshin Ulziisai-khan met with Ambassador Extraordinary and Plenipotentiary of the Republic of Kazakhstan to Mongolia Zhalgas Zh. Adilbayev. During the meeting, the two sides exchanged views on the possibility of charter flights between Mongolia and Kazakhstan.

Mongolia has more than 100 citizens who have requested to return to Kazakhstan, most of whom are in Bayan-Ulgii province. Meanwhile, more than

1,000 Mongolian citizens have applied to return home from Kazakhstan as well.

Deputy Prime Minister Enkh-tuvshin Ulziisai-khan said, "We had planned to conduct a charter flight to Kazakhstan. In terms of time, I assume it will be in the first half of June. I believe it will be under control."

Over 9,400 cases of COVID-19 cases have been registered in Kazakhstan of which 4,600 people have been discharged from hospital, according to the Office of the Deputy Prime Minister of Mongolia.

Total COVID-19 cases rise by 13, reaching 161

According to the National Center for Communicable Diseases, 13 new COVID-19 cases which are all imported from Russia were confirmed as a result of tests taken from 517 citizens on May 27, bringing the total number of confirmed cases to 161.

The novel coronavirus was detected in a student, who arrived by a Moscow-Ulaanbaatar charter flight on May 26, as a result of his repeated testing, as well as in 12 out of 340, who returned on May 26 from Russia through Altanbulag border

checkpoint. Ten of them are students. Currently, 43 citizens has been recovered and 118 patients are being treated in NCCD. Approximately 11 patients' health condition is a bit severe according to the daily briefing of the Ministry of Health.

On May 26 and 27, a total of 570 Mongolians, mostly students, came through the Altanbulag vehicle crossing border checkpoint in Selenge province. They were directly brought to Ulaanbaatar city on a charter train to be placed under 21-day mandatory isolation.

ХЭРЭГЛЭГЧИЙН ТУРШЛАГАД СУУРИЛСАН ЖИЖИГЛЭН ХУДАЛДААНЫ САЛБАРЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

/Хүнсний сүлжээ дэлгүүрүүдийн жишээн дээр/

Б.Амарзаяа, СЭЗИС-ийн магистрант

Байгууллагын өрсөлдөх чадварыг тодорхойлох үзүүлэлтийн нэг нь тухайн бүтээгдэхүүн үйлчилгээний чанар бөгөөд түүнийг тодорхой түвшинд барьж байх нь байгууллагын амин чухал зорилт байдаг. Үйлчилгээний чанар нь тодорхой хэрэгцээг хангах чадвараар илэрхийлэгдэх бүтээгдэхүүн үйлчилгээний онцлог болон шинж чанаруудын нийлбэр бөгөөд жижиглэн худалдааны компаниуд өөрсдийн үйлчлүүлэгчдэдээ үнэ цэнийг бий болгохын ач холбогдлыг ойлгосон байх нь чухал. Зөвхөн бүтээгдэхүүн үйлчилгээг бий болгох нь хангалтгүй бөгөөд байгууллага нь үйлчлүүлэгчдэдээ сэтгэл ханамж бүхий туршлагыг үлдээж байх нь компанийн хөгжилд чухал үүрэгтэй. Хэрэглэгчийн туршлага нь компаниудын хувьд зах зээл

дээр байр сууриа тогтвортой хадгалж авч үлдэх нэг эх үүсвэр болж байна. Түүхээс харвал бараа бүтээгдэхүүн, үнэ, хүмүүс, технологи бүгд ижил төстэй үед хэрэглэгчийн туршлага нь ялгарах хүчин зүйл болдог.

Дэлхийн том сүлжээ супер-маркет, хүнсний дэлгүүрүүд сүүлийн 50 гаруй жилд ямар ч онц сүртэй шинэчлэлт хийсэнгүй. Нэг цэгийн үйлчилгээ, байршил сайтай газар, хямд үнэ, тухлаг орчныг хаана ч бүрдүүлэх зах зээл тийм ч амар зүйл биш. Тэгсэн хэдий ч судлаачид 1970-аад эхэн үетэй харьцуулахад дорвитой өөрчлөлтгүй гэж үзэж байгаа нь "Шинэчлэлт"-ийн тухай хөндөж буй хэрэг. Технологийн дэвшил жижиглэн худалдааны салбарт тасралтгүй хурдацтай нэвтэрч байгаа нь ирээдүйд энэ салбарт дараах өөрчлөлтүүд гарах магадлалтайг харуулж байна.

2018 онд Амстердам хотноо

болсон "World Retail Congress 2019" хурлаар худалдааны салбарт дараах үзүүлэлтүүдийг чухал хэмээн онцолжээ.

Шуурхай байдал: Хурдтай, тав тухтай үйлчилгээ нь үйлчлүүлэгчийг татах үндсэн хоёр чанар болж байна.

Худалдан авагчийн зан төлөв: Худалдааны байгууллагын стратеги, шийдвэр гаргалтын гол эх үүсвэр нь худалдан авагчийн зан төлөв, ойлголт, хэрэглээний талаар дэлгэрэнгүй мэдээлэл юм. Хэрэглэгчдийнхээ талаар илүү сайн ойлгох, тэднийг илүү сэтгэл ханамжтай болгохын тулд хэрэглэгч, худалдан авагчийн зан төлөвийг судлах судалгаанд хөрөнгө оруулах болон олон эх сурвалжийн өгөгдлийг ашиглах нь үр өгөөжтэй.

Олон нийтийн сүлжээ: Ухаалаг утас хэрэглэгчдийн 87% нь олон нийтийн сүлжээнд идэвхтэй байна.

Төлбөр төлөлтийн хялбар байдал: Төлбөр төлөлтийн олон сонголтыг хэрэглэгчдэд санал болгох буюу гар утаснаас төлбөр тооцоогоо хийх боломж бүхий технологийг нэвтрүүлсэнээр давуу тал бий болно.

Онлайн хэлбэр: /Конвенсис сторийн хэлбэр/ Walmart гэх мэт томоохон дэлгүүрүүд нь сүүлийн жилүүдэд хүчээ авч байгаа боловч хэрэглэгчид бага хэмжээний дэлгүүрээр илүү үйлчлүүлэх хандлагатай байна. Target, Best buy, Ikea зэрэг томоохон байгууллагууд энэ байдлыг урьдчилан харж хөрөнгө оруулалтаа хийж эхлээд байна. Худалдан авагч талбай томтой дэлгүүрийн эцэс төгсгөлгүй эгнээгээр хэсч хугацаа алдахыг хүсдэггүй байдал болон онлайн дэлгүүрээр үйлчлүүлэх боломж нэмэгдэж байгаа гэх мэт шалтгааны улмаас худалдан авагчид бага хэмжээний дэлгүүрийг сонирхох болсон.

Омни суваг: Хэрэглэгчдэд онлайн болон оффлайн бүх боломжит сувгуудаар бараа бүтээгдэхүүн авах боломжийг омни-суваг стратеги олгодог. Жишээ нь: Facebook Messenger-ээр Domino-д захиалга өгч болдог бол Starbucks-аас мобайл аппликейшнийг ашиглан захиалга өгч болдог байна. Ирээдүйд онлайн болон оффлайн шийдлүүдийг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн дэлгүүрүүд бусдаас давуу талтай байх болно.

Манай улсад жижиглэн худалдааны салбарт ижил төрлийн үйл ажиллагаа бүхий олон компаниуд гарч ирснээр өрсөлдөөн ширүүсч зах зээлд эзлэх байр суурийн төлөөх тэмцэл бизнест тасралтгүй явагдаж, тэргүүлэгч байгууллага болохын тулд үйлчилгээний чанарын асуудал нь цаашид ч чухал байр суурийг эзэлсээр байна.

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2020 оны 05 дугаар сарын 29.

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН НЭР: XII.1.2.33 "Сургуулийн барилгын их засвар /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 27 дугаар, 102 дугаар сургууль/" төсөл, арга хэмжээний гүйцэтгэчийг сонгон шалгаруулах тендер.

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ДУГААР: БСШУСЯ/202001139

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Төрийн худалдан авах ажиллагааны газар нь эрх бүхий тендер оролцогчдоос XII.1.2.33 "Сургуулийн барилгын их засвар /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 27 дугаар, 102 дугаар сургууль/" ажлыг гүйцэтгэх тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу. Тендер шалгаруулалтыг Сангийн сайдын 2019 оны 255 дугаар тушаалаар батлагдсан "Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журам"-ын дагуу зохион байгуулж байна.

Тендер оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө **50,000.00 (Тавин мянга)** төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс хойш **30 хоногийн** хугацаанд хүчинтэй байна.

Тендер оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах

шаардлагыг хангасан байна.Үүнд:

Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 3 жил буюу 2017, 2018, 2019 онуудын аль нэг жилийн борлуулалтын орлогын хэмжээ нь батлагдсан төсөвт өртгийн 20 хувиас багагүй байна.

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүн: Батлагдсан төсөвт өртгийн үнийн дүнгийн 20 хувиас багагүй байна.

Ижил төстэй ажлын өртөг: Сүүлийн 3 жил буюу 2017, 2018, 2019 онуудын аль нэг жилд батлагдсан төсөвт өртгийн үнийн дүнгийн 20 хувиас доошгүй хэмжээний ижил төстэй барилга засварын ажлын ерөнхий гүйцэтгэгчээр ажиллаж улсын комисст хүлээлгэн өгсөн байна.

Тусгай зөвшөөрөл шаардлагатай эсэх: тийм

Дараах тусгай зөвшөөрөл шаардлагатай:

БА-2.1. Цутгамал болон угсармал төмөр бетон, мод ба өрөгт бүтээцэн барилгын угсралт, өргөтгөл, шинэчлэлийн ажил,

БА-8.1. Барилга байгууламжийн засвар, засал чимэглэл, интерьер, орчны тохижилтын ажил

Тендерийн баталгааны дүн: 6,960,000.00 (зургаан сая есөн зуун жаран мянган) төгрөг.

Монгол Улсын хуулийн этгээд тендерийн баталгааг банкны баталгаа, Монгол Улсын Засгийн газрын бонд, эсхүл Монгол Улсын Засгийн газраас зөвшөөрсөн үнэт цаасны хэлбэрээр ирүүлж болно.

Тендерийн материалд цахим тендерийн баталгааг хавсарган ирүүлэх шаардлагагүй бөгөөд цахим систем тендерийн баталгаа гаргагч арилжааны банкны мэдээллийн сангаас тендер оролцогчийн тендерийн баталгааны талаарх мэдээллийг шалгана.

Тендерийг **2020 оны 06 дугаар 29-ний өдрийн 10.30 цагаас өмнө** цахим системээр илгээх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендер оролцогчдыг байлцуулан тендерийг **2020 оны 06 дугаар 29-ний өдрийн 11.00 цагт** нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй.

Дотоодын давуу эрх тооцно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ,
ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР,
УЛААНБААТАР ХОТ, БАЯНЗҮРХ ДҮҮРЭГ,
1 ДҮГЭЭР ХОРОО,
ЭНХТАЙВАНЫ ӨРГӨН ЧӨЛӨӨ-16А,
ЗАСГИЙН ГАЗРЫН IX БАЙР,
УТАС: 260061, 260056
ЦАХИМ ХАЯГ: WWW.TENDER.GOV.MN**

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2020 оны 05 дугаар сарын 29.

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН НЭР: XII.1.1.288 "Цэцэрлэгийн барилга, 200 ор /Баян-Өлгий, Өлгий сум/ төсөл, арга хэмжээний гүйцэтгэчийг сонгон шалгаруулах тендер.

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ДУГААР: БСШУСЯ/202001308

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Төрийн худалдан авах ажиллагааны газар нь эрх бүхий тендер оролцогчдоос XII.1.1.288 "Цэцэрлэгийн барилга, 200 ор /Баян-Өлгий, Өлгий сум/ ажлыг гүйцэтгэх тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу. Тендер шалгаруулалтыг Сангийн сайдын 2019 оны 255 дугаар тушаалаар батлагдсан "Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журам"-ын дагуу зохион байгуулж байна.

Тендер оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө **50,000.00 (Тавин мянга)** төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс хойш **30 хоногийн** хугацаанд хүчинтэй байна.

Тендер оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.Үүнд:

Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 3 жил буюу 2017, 2018, 2019 онуудын борлуулалтын орлогын дундаж хэмжээ

нь батлагдсан төсөвт өртгийн 40 хувиас багагүй байна.

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүн: Батлагдсан төсөвт өртгийн үнийн дүнгийн 40 хувиас багагүй байна.

Ижил төстэй ажлын өртөг: Сүүлийн 3 жил буюу 2017, 2018, 2019 онуудын аль нэг жилд доод тал нь нэг удаа батлагдсан төсөвт өртгийн үнийн дүнгийн 40 хувиас доошгүй хэмжээний ижил төстэй ажлын ерөнхий гүйцэтгэгчээр ажиллаж улсын комисст хүлээлгэн өгсөн байна.

Тусгай зөвшөөрөл шаардлагатай эсэх: тийм

Дараах тусгай зөвшөөрөл шаардлагатай:

БА-2.1. Төмөр бетон, мод ба өрөгт бүтээцэн барилгын угсралт, өргөтгөл, шинэчлэлийн ажил,

БА-6.1. Барилга байгууламжийн дотор ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, тэдгээрийн тоног төхөөрөмж, гадна салбар шугам сүлжээний угсралт

БА-6.2. Барилгын барилга байгууламжийн дотор халаалт, салхивчийн шугам сүлжээ, тэдгээрийн тоног төхөөрөмж, гадна салбар шугам сүлжээний угсралт

БА-6.3. Барилга байгууламжийн дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамжийн угсралт, тэдгээрийн тоног төхөөрөмж, тухайн барилгын гадна салбар шугам сүлжээний угсралт,

БА-6.4. Барилга байгууламжийн дотор холбоо дохиолол, интернэт сүлжээ, гал унтраах болон галын аюулын дохиоллын системийн угсралт, тэдгээрийн тоног төхөөрөмж, тухайн барилгын гадна салбар шугам сүлжээний угсралт.

БА-8.1. Барилга байгууламжийн засвар, засал чимэглэл,

интерьер, орчны тохижилтын ажил

Тендерийн баталгааны дүн: 25,000,000.00 (хорин таван сая) төгрөг.

Монгол Улсын хуулийн этгээд тендерийн баталгааг банкны баталгаа, Монгол Улсын Засгийн газрын бонд, эсхүл Монгол Улсын Засгийн газраас зөвшөөрсөн үнэт цаасны хэлбэрээр ирүүлж болно.

Тендерийн материалд цахим тендерийн баталгааг хавсарган ирүүлэх шаардлагагүй бөгөөд цахим систем тендерийн баталгаа гаргагч арилжааны банкны мэдээллийн сангаас тендер оролцогчийн тендерийн баталгааны талаарх мэдээллийг шалгана.

Тендерийг **2020 оны 06 дугаар 29-ний өдрийн 10.30 цагаас өмнө** цахим системээр илгээх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендер оролцогчдыг байлцуулан тендерийг **2020 оны 06 дугаар 29-ний өдрийн 11.00 цагт** нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй.

Дотоодын давуу эрх тооцно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ,
ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР,
УЛААНБААТАР ХОТ, БАЯНЗҮРХ ДҮҮРЭГ,
1 ДҮГЭЭР ХОРОО,
ЭНХТАЙВАНЫ ӨРГӨН ЧӨЛӨӨ-16А,
ЗАСГИЙН ГАЗРЫН IX БАЙР,
УТАС: 260061, 260056
ЦАХИМ ХАЯГ: WWW.TENDER.GOV.MN**

ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Огноо: 2020 оны 5 дугаар сарын 29.

Төрийн худалдан авах ажиллагааны газар нь сонгогдсон эрх бүхий тендер оролцогчдоос XII.1.1.254 "Сургуулийн спорт заалын барилга /Хэнтий, Хэрлэн сум/" төсөл, арга хэмжээг гүйцэтгэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх ажлын зураг, техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг 2020 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн 09.10 цагаас цахим системээр www.tender.gov.mn хаягаар илгээх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендер оролцогчдыг байлцуулан тендерийг 2020 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн 09.40 цагт нээнэ.

Дотоодын давуу эрх тооцно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ,
ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР,
УЛААНБААТАР ХОТ, БАЯНЗҮРХ ДҮҮРЭГ, 1 ДҮГЭЭР ХОРОО,
ЭНХТАЙВАНЫ ӨРГӨН ЧӨЛӨӨ-16А, ЗАСГИЙН ГАЗРЫН IX БАЙР,
УТАС: 260115, 260056
ЦАХИМ ХАЯГ: WWW.TENDER.GOV.MN,**

ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Огноо: 2020 оны 5 дугаар сарын 29.

Төрийн худалдан авах ажиллагааны газар нь сонгогдсон эрх бүхий тендер оролцогчдоос XVII.1.48 "Сум дундын эмнэлгийн амбулаторийн барилга /Завхан, Завханмандал сум/" төсөл, арга хэмжээг гүйцэтгэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх ажлын зураг, техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг 2020 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 09.00 цагаас өмнө цахим системээр илгээх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендер оролцогчдыг байлцуулан тендерийг 2020 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 09.30 цагт нээнэ.

Дотоодны давуу эрх тооцно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ,
ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР,
УЛААНБААТАР ХОТ, БАЯНЗҮРХ ДҮҮРЭГ, 1 ДҮГЭЭР ХОРОО,
ЭНХТАЙВАНЫ ӨРГӨН ЧӨЛӨӨ-16А, ЗАСГИЙН ГАЗРЫН IX БАЙР,
УТАС: 260061, 260056
ЦАХИМ ХАЯГ: WWW.TENDER.GOV.MN,**

ӨРНИЙН ЗУРХАЙ

Охины ордынхон их мөнгөтэй болох боломж тохионо

Хонь /III.21-IV.19/
Өөрийгөө хөгжүүлэх, мэдлэг мэргэжлээ дээшлүүлэх, туршлага судлах зэрэг оюуны хөрөнгө оруулалт хийхэд таатай. Харин шинээр ажил эхлүүлэх, томоохон мөнгөн дүнтэй хөрөнгө оруулалт хийх, худалдан авалт зэрэг нь амжилт авчрахгүй. Та өөрийн мөрөөдлийн төлөө тууштай тэмцэгч байж чадвал ирээдүйд их боломжийг атгах болно.

Мэлхий /VI.22-VII.22/
Төрийн байгууллагад хандах гэж байгаа бол цагаа маш сайн тооцоолох хэрэгтэй. Олон хүнтэй харьцахад хүндрэл бэрхшээлтэй тул та ч мөн адил бусдыг ойлгох сэтгэлтэй бай. Орлогоо нэмэгдүүлж, зарлагаа багасгах тал дээр дорвитой арга хэмжээ ав. Янаг амрагийн явдалд орооцолдох хэрэггүй. Бүтэлгүй зүйлтэй учирна.

Жинлүүр /IX.23-X.22/
Өөрийнхөө зорилгыг биелүүлэхээс шантарч, хулчийх хэрэггүй. Танд боломж бага байлаа ч жижигхэн гэрлийг харж, урам орон тууштай зүтгэ. Таны уйгагүй хөдөлмөрч зан чанар нөлөө бүхий хүний анхаарлыг татаж чадна. Үзэл санаа, амьдралын хэвшил өөр ч гэлээ бусдын асуудалд хошуу дүрэхгүй байхыг зөвлөж байна.

Матар /XII.22-I.19/
Хэн нэгэнтэй зөрчилдөж өөрийгөө хянаж чадахгүй болтлоо бухимдаж магадгүй. Хэт сэтгэлийн хөөрөл нь юунд ч хүргэж болзошгүй тул өөрөө өөртөө хяналттай байгаарай. Олон хүний өмнө гарах шаардлага тулгарч болзошгүй. Бага зэргийн алдаа таны нэр хүндийг сэвтээж болзошгүй.

Үхэр /IV.20-V.20/
Од гараг таны ажилч хичээнгүй байдлыг үнэлж, тусламж илгээхэд бэлэн байна. Урам зоригийг тань сэргээсэн маш их ашиг орлогыг олж мэдэх төсөл төлөвлөгөөний санал ирэх бололтой. Бүхий л харилцаагаа эелдэг зөөлөн байлгаж, ажил хэргийн болон бусад асуудлаар хандсан хүмүүсийг өөртөө ойр хүлээж ав. Чин сэтгэлээсээ хандаарай.

Арслан /VII.23-VIII.22/
Өөртөө ахадсан, хүч хүрэхээргүй зүйл рүү тэмүүлэх хэрэггүй. Танд аав ээжээс өгсөн зөвлөгөө хамгийн үнэтэй байх болно. Оюун санаа, бодол тань бусдын гаргасан ололт, амжилт дээр төвлөрнө. Та тэднээс туршлага судалж суралцахыг хүснэ. Оюутнуудын ирээдүйд шинэ боломж гарч ирнэ. Тэдэнд сонголт хийх шаардлага тулгарах ч ганцаар шийдвэрлэж чадахгүйд хүрнэ.

Хилэнц /X.23-XI.22/
Мэдэгдэхгүй гэнэт гарч ирэх зардалд зориулж хуримтлал цуглуулах, санхүүгийн хүндрэл бэрхшээлээс урьдчилан сэргийлэх арга зам хай. Томоохон хэмжээний худалдан авалт хийх, урьд нь төлөөгүй өрөө төлөх зэргээр мөнгөтэй холбоотой асуудал гарна. Өөрийн хүч хөдөлмөрийг хэрэггүй зүйлд зарцуулах хэрэггүй. Дүү нартаа үлгэр дуурайл болох ямар нэгэн тустай, сайн үйлс хийхийг зорь.

Хумх /I.20-II.18/
Ямар ч зүйл дээр яаран сандран шийдвэр гаргахгүй байж, өөрийгөө удирдахыг хичээ. Өөрийн тогтвортой байдлыг хамгаалах зарим нэг оролдлогыг хийнэ. Ажлын хамтрагчаа анхаарлын төвд байлгаж, түүнд бүрэн дүүрэн итгэхийг хүснэ. Гэвч таны хүссэн зүйл болохгүй. Болж буй нөхцөл байдлаас та өөрөө алдаж хоцорно. Аливаа зүйлд маш няхуур, болгоомжтой хандахыг анхааруулж байна.

Хамтатгах /V.21-VI.21/
Зорилгодоо хүрэхийн тулд шаардлагатай бүх авьяас чадвараа харуулах. Та хэн нэгний хувьд хамгийн таагүй, муу хүн нь болж болзошгүй. Сайн найз, сайхан хамтрагчийнхаа ачаар ертөнцийг үзэх үзэл тань өөрчлөгдөж, бүхнийг өөр өнцгөөс харахыг хичээнэ. Олон олон төлөвлөгөө боловсруулах гэж хичээнгүйлэн ажиллана.

Охин /VIII.23-IX.22/
Сэтгэл санаагаа хянаж, ажил хэрэг болон амьдралдаа идэвх зүтгэлтэй байхыг зөвлөж байна. Хэт сэтгэл гутрал нь сайн зүйлд хүргэхгүй. Их мөнгөний бараа харах боломж тохионо. Энэ нь таны амьдралыг өөрчилж хүрэхүйц байж магадгүй. Өнгөрсөн таагүй зүйлдээ баригдан урагшаа нэг ч алхам хийж чадахгүй байгаадаа та сэтгэлээр унана.

Нум /XI.22-XII.21/
Алсын тээвэрт явдаг болон аялал жуулчлалын ажил хийдэг хүмүүст таатай нөхцөл бүрдэж магадгүй. Тэнцвэртэй, үнэнч шударга байхыг нийгэм танаас шаардах болно. Эргэн тойронд чинь гарч буй өөрчлөлтийг эерэгээр хүлээж ав. Мөн та өөртөө хэрэгжүүлэх талаар бодож үзэх хэрэгтэй. Хайр дурлалын асуудал тань бүтэмжтэй байх болно.

Загас /II.19-III.20/
Танд өдөр тутмын ажил тань уйтгартай санагдаж, өөр шинэ содон сонирхолтой зүйл хийхийг хүснэ. Магадгүй дуртай зүйлээ ажил хэрэг болгож, мөнгө олох боломж боллоцоог судалж эхэлнэ. Бодож байсан төлөвлөгөө бүтэхгүйд хүрч, итгэл найдвараа алдаж магадгүй. Аяллаар хэд хоногоор явах, амралт авах нь таны сэргэлтийн үе байх болно.

ДОРНЫН ЗУРХАЙ

Үс засуулбал хэрүүл тэмцэл ирнэ



Үс засуулбал:
Хэл ам, хэрүүл тэмцэл ирнэ
Наран ургах, шингэх:
04:59-20:40 цаг
Барилдлага: Түлэх
Шүтэн барилдлага:
Төрөхүй
Суудал: Гал

Аргын тооллын тавдугаар сарын 29, Сугар гараг. Билгийн тооллын 7, их морь одтой, хар бич өдөр.
Өдрийн наран 04:59 цагт мандан, 20:40 цагт жаргана. Тухайн өдөр хулгана, луу жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бар, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр архи уух, тамхи татах, сэтгэл муутантай нөхөрлөх зэргийг цээрлэх хэрэгтэй ба сан тавиулах, угаал үйлдэх, бүжиг наадам хийх, цэцэрлэг байгуулах, урлан бүтээхэд сайн. Хувцас эсгэх, шинэ хувцас өмсөх, зөвлөгөө хийх, сэтгэлд сэвтэй газар очиход муу. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, луу, могой, хонь, нохой болой. Хол газар яваар одогсод зүүн урагш мөрөө гаргавал зохистой. Тэрсүүд өдөр. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

ЗГМ: ҮГИЙН СҮЛЖЭЭ

1		2		3		4		5
6			7			8		
		9				10		
11						12		
13		14		15				16
17						17		

БОСООГООР:

- Өндөр гэгээн Занабазарын мэлмий гийсний ойд зориулсан даншиг наадамд түрүүлсэн Д.Ганбаатар (МАКС)-ын хурдан азарганы нэр
- Маш их (... хичээнгүй)
- Бөртэ хатны төрөлх овог аймаг
- Этгээд, зүгээргүй
- Говь-Алтай аймгаас сонгогдсон УИХ-ын гишүүн
- Монгол гэрийн өрхний завсраар хөндлөн татдаг оосор бүч
- Адууны дотор мах
- Үстэй дулаан хувцас
- Анхны гурван оронтой тоо

ХӨНДЛӨНГӨӨР:

- Шигшмэл хурдан морьдын "Их хурд" анхны уралдаанд манлайлсан Буяндэлгэрийн хурдан азарга
- Хэсэг ноёд Жамухыг Чингисийн эсрэг турхирч түүнд өргөмжилсөн цол ...хан
- Социализмын үеийн Засгийн газрын танхим (товчилсон нэр)
- Хатгалдах зэвсэг
- Нас гүйцээгүй эр адуу
- Тэсрэх бодис
- Хүргэн, бэрийн талынхан
- 10-ын зургаан зэрэг
- Манай улсын экспортын гол өнгөт металл
- Зөвлөлт, Монголын сансрын II багийн дарга, ЗХУ, БНМАУ-ын баатар
- Чингис хааны цэргийн магнайд мангудтай хамт довтолдог асан овог аймаг

Өмнөх дугаарын хариу 05.28

Л	И	Т				С	Н	З
А		О	В	О	О	Т		А
Н	Я	Р		Й		Е	Х	Х
Т		Н	А	Г	А	Й		И
А	Г	А		О		Н	А	Р
Н		Д	А	Н	Т	Е		А
З	О	О				Ц	Ө	Л

ЗГМ: СУДОКУ

			8			2		
			1	4				
	7				9		8	
7								3
2	1	8						7
		4		5	7			
				6		4		
3	8	1	9					
		5		1	3			

Өмнөх дугаарын хариу

8	7	5	2	4	3	9	4	6
3	9	4	8	1	6	1	2	5
6	2	1	5	9	7	2	9	3
2	5	6	4	8	1	4	5	7
1	4	9	3	7	5	9	8	2
7	3	8	9	6	2	8	3	4
9	6	3	1	5	4	5	7	8
5	1	2	7	3	8	7	6	9
4	8	7	6	2	9	6	3	1

ГУТААР ЗАГАСТАЙ ШӨЛ



✂ Т.Намуун, ЗГМ сонин

Манай сонин “Гал тогоо” булангаа Монголын ахлах тогоочийн академитай хамтран хүргэж буй билээ. Ингээд тус академийн ерөнхийлөгч, Монгол Улсын мастер тогооч, үйлчилгээний гавьяат ажилтан Д.Буяндэлгэрийн гутаар загастай шөл хийх жорыг хүргэж байна.

ОРЦ:

Гутаар загас-120 гр
Төмс-140 гр
Мөрөг загасны цөвдөл-56 гр
Бөөрөнхий сонгино-12 гр
Цөцгийн тос-10 гр
Ногоон гоньд-2 гр
Ногоон яншуй-2 гр
Загасны шөл-450 гр

ХЭРХЭН ХИЙХ ВЭ:

Загасаа урьдчилан чанах бөгөөд цөвдөл болон яс, сэлүүр зэргийг шөл гаргаж авсны дараа сайтар шүүнэ. Буцалж буй шөлөнд том хэрчсэн сонгино болон төмсөө бүтнээр нь хийж, чанаарай. Шөл болохоос 15 минутын өмнө урьдчилан бэлтгэсэн загасны махаа нэмж хийх бөгөөд бэлэн болсон шөлөн дээрээ цөцгийн тос дусаагаад, яншуй болон ногоон сонгино цацаж чимэглээрэй.

ШИМ ТЭЖЭЭЛИЙН МЭДЭЭЛЭЛ:

Нийт илчлэг: 253 ккал
Уураг: 52.9 гр
Нүүрс ус: 24.72 гр
Өөх тос: 11.54 гр



Такесан мисо рамен
хүргэлттэй боллоо



f Takesan Miso Ramen

Ширээ захиалгын утас:

7706-1212

Захиалгын утас:

7766-7766

Хүргэлтийн захиалгын утас:

SONGO 7000-3222